МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

# ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

Улаанбаатар хот
2011 он

DDC
330’021’517
Э-19

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
http://www.nso.mn
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

ISBN 978-99929-64-68-5

# АГУУЛГА

Судалгаа бичихэд оролцогчид ..... iv

Хүснэгтийн жагсаалт ..... v

Зургийн жагсаалт ..... vi

Хавсралт хүснэгтийн жагсаалт ..... vii

Товчилсон үгийн тайлбар ..... viii

Өмнөх үг ..... 1

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
Ерөнхий зүйл ..... 3

ХОЁРДУГААР БҮЛЭГ.
Эдийн засгийн идэвх буюу ажиллах хүчний байдал ..... 15

ГУРАВДУГААР БҮЛЭГ.
Хөдөлмөр эрхлэлт ..... 39

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
Ажилгүй иргэд ..... 51

ТАВДУГААР БҮЛЭГ.
Бүс нутгийн болон аймгийн ялгаа ..... 61

Дүгнэлт, зөвлөмж ..... 69

Хавсралт ..... 75

Ашигласан ном, товхимол ..... 89

# СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

## НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

**Нярм-Очирын Должинсүрэн**
Эдийн засагч
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах шинжээч

**Дашнамжилын Насандэлгэр**
Эдийн засагч - Статистикч
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын шинжээч

**Сүхбаатарын Дарьмаа**
Математикч - Статистикч
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын шинжээч

## ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

**Баатарын Эрдэнэсүрэн**
Үйлдвэрийн инженер-эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор, профессор
ҮСХ-ны дэд дарга

**Баясгалангийн Ганбат**
Статистикч, Эдийн засгийн ухааны доктор
ҮСХ-ны Ерөнхий менежер, Тамгын газрын дарга

**Бидэрьяагийн Цэрэнханд**
Программ зохиогч, Тооцоолох техникийн инженер
ҮСХ-ны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1.1 Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он........8
Хүснэгт 1.2 Өрхийн тоо, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он........9
Хүснэгт 1.3 Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа, 2010 он........9
Хүснэгт 1.4. Хүн ам зүйн ачаалал, 1989, 2000, 2010 он........11
Хүснэгт 1.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он........14
Хүснэгт 2.1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн байдал, 2000, 2010 он........16
Хүснэгт 2.2 Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он........17
Хүснэгт 2.3 Эдийн засгийн идэвхтэй хүн ам, бүс, аймаг, нийслэл, хот, хөдөө, хүйсээр, 2010 он........18
Хүснэгт 2.4 Ажиллах хүчний оролцооны түвшин, 2000, 2010 он........19
Хүснэгт 2.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он........20
Хүснэгт 2.6 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2010 он........21
Хүснэгт 2.7 Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2010 он........22
Хүснэгт 2.8 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2010 он........22
Хүснэгт 2.9 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он........23
Хүснэгт 2.10 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, хот, хөдөөгөөр, аймгаар, 2010 он........24
Хүснэгт 2.11 Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөө, хүйс, боловсролын түвшин, хувиар, 2010 он........25
Хүснэгт 2.12 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, боловсролын түвшингээр, 2010 он........26
Хүснэгт 2.13 Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшин, аймгаар, 2010 он........28
Хүснэгт 2.14 Ажиллах хүчний оролцооны түвшин, гэр бүлийн байдал, хүйсээр, 2000, 2010 он........29
Хүснэгт 2.15 Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он........30
Хүснэгт 2.16 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он........32
Хүснэгт 2.17 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, хот, хөдөө, шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он........32
Хүснэгт 2.18 Ажиллах хүчний оролцооны түвшин, аймаг, нийслэл, сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он........34
Хүснэгт 2.19 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, 2000, 2010 он........35
Хүснэгт 2.20 Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он........36
Хүснэгт 2.21 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, боловсролын түвшингээр, 2010 он........37
Хүснэгт 3.1 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, хот, хөдөө хүйсээр 2000, 2010 он........40
Хүснэгт 3.2 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр 2000, 2010 оноор........41
Хүснэгт 3.3 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он........41
Хүснэгт 3.4. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, хувиар, 2010 он........43

Хүснэгт 3.5. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хот, хөдөөгөөр, 2010 он ....44
Хүснэгт 3.6. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, ажил мэргэжлийн ангилал, хүйс, хувиар, 2010 он....45
Хүснэгт 3.7. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар, 2000, 2010 он ....45
Хүснэгт 3.8 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын гэрлэлтийн байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2000, 2010 он ....46
Хүснэгт 3.9 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо гэрлэлтийн байдал, хүйсээр, 2000, 2010 он ....47
Хүснэгт 3.10 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын боловсролын түвшин, хүйсээр, 2000, 2010 он ....47
Хүснэгт 4.1 Ажилгүй иргэдийн тоо, хот, хөдөө, бүс, хүйсээр, 2000, 2010 он....53
Хүснэгт 4.2 Арван тав, түүнээс дээш насны хүн амд ажилгүй иргэдийн эзлэх хувь, хүйс, бүс нутгаар, 2000, 2010 он ....53
Хүснэгт 4.3 Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр, 2000, 2010 он ....54
Хүснэгт 4.4 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр 2000, 2010 он....55
Хүснэгт 4.5 Ажилгүйдлийн түвшин,насны бүлэг, боловсролын түвшин, хувиар, 2010 он ....57
Хүснэгт 4.6 Ажилгүйдлийн түвшин,насны бүлэг, боловсролын түвшингээр, хувиар, 2010 он....58
Хүснэгт 4.7 Ажилгүйдлийн түвшин,насны бүлэг, боловсролын түвшингээр, хувиар, 2010 он....59
Хүснэгт 5.1 Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллах хүчний оролцооны түвшин, бүс, аймаг, нийслэл, 2000, 2010 он ....62
Хүснэгт 5.2 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, аймаг, нийслэл, хүйсээр 2000, 2010 он ....65
Хүснэгт 5.3 Ажилгүй иргэдийн тоо, ажилгүйдлийн түвшний аймаг хоорондын ялгаа, аймаг, бүсээр, 2000, 2010 он....67

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Эдийн засгийн идэвхийн байдлыг тодорхойлоход хэрэглэсэн асуулт, ХАОСТ- 2010 ..... 6
Зураг 1.2. Эдийн засгийн идэвхгүй байгаагийн шалгаан, 2000, 2010 он .... 7
Зураг 1.3. Хүн амын насны бүтэц, 1979, 1989, 2000, 2010 он....10
Зураг 1.4. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, 2000, 2010 он ....11
Зураг 1.5. Нийт хүн ам, эдийн засгийн идэвхтэй хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он ....12
Зураг 1.6. Арван тав, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хувиар, 2000, 2010 он....13
Зураг 1.7. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшин, хувиар, 2010 он ....13
Зураг 2.1 Нийт эдийн засгийн идэвхтэй хүн амд боловсролтой, боловсролгүй хүн амын эзлэх хувь, 2000, 2010 он.....19
Зураг 2.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2010 он.... 20
Зураг 2.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, бүс, хүйс, хувиар, 2010 он.....24
Зураг 2.4 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, боловсролын түвшингээр, 2010 он.... 26
Зураг 2.5 Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин боловсролын түвшин, насны бүлгээр, 2010 он.....27

Зураг 2.6 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшин, насны бүлгээр, 2010 он. ........ 28
Зураг 2.7. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2010 он ........31
Зураг 2.8. Ажиллах хүчний оролцооны түвшин, сүүлийн 1 жилийн шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он ........ 33
Зураг 2.9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөний байдлаар, 2000, 2010 он ........ 33
Зураг 2.10. Эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц, шалтгаан, хүйсээр, 2010 он. ........ 38
Зураг 3.1 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, хүйсээр, 2000, 2010 он ........ 42
Зураг 3.2 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбаруудаар, 2000, 2010 он ........ 42
Зураг 3.3 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын гэрлэлтийн байдал, 2000, 2010 он ........ 46
Зураг 3.4 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он ........ 48
Зураг 3.5 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын сүүлийн таван жилийн шилжилт хөдөлгөөн, 2010 оны тооллогоор ........ 48
Зураг 3.6 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он ........ 49
Зураг 3.7 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он ........ 49
Зураг 3.8 Хөгжлийн бэрхшээлтэй ажил эрхэлдэг хүн ам, насны бүлгээр, 2010 он ........ 50
Зураг 4.1. Ажилгүй иргэдийг тодорхойлох асуулт, 2010 он ........ 52
Зураг 4.2 Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, байршлаар, 2000, 2010 он ........ 54
Зураг 4.3 Ажилгүй иргэд, шилжих хөдөлгөөний байдлаар, 2010 он ........55
Зураг 4.4 Ажилгүй иргэд, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он ........ 56
Зураг 4.5 Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй иргэд, хэлбэрээр, 2010 он ........ 56
Зураг 5.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, аймаг, нийслэлээр, 2010 он ........ 64
Зураг 5.2 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эрхэлдэг ажил мэргэжлээр, 2010 он ........ 65
Зураг 5.3. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн байдалаар, 2010 он ........ 66
Зураг 4.2 Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он ........ 68

# ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Арван тав, түүнээс дээш насны суурин хүн амын хөдөлмөр эрхлэлт, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгээр........76
Хүснэгт 2. Ажиллах хүчний оролцооны түвшин, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он ........ 79
Хүснэгт 3. Эдийн засгийн идэвхтэй хүн ам, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он ........81
Хүснэгт 4. Арван тав, түүнээс дээш насны хүн ам, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он ........ 84
Хүснэгт 5. Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, аймаг, нийслэлээр, 2010 он........ 87
Хүснэгт 6. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он ........ 88

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| АХС | Ажиллах хүчний судалгаа |
| АХОТ | Ажиллах хүчний оролцооны түвшин |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ҮАМА | Үндэсний ажил мэргэжлийн ангилал |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХАОСТ | Хүн ам, орон сууцны тооллого |
| ЭЗИХА | Эдийн засгийн идэвхтэй хүн ам |
| ЭЗБТҮАСА | Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал |

# ӨМНӨХ ҮГ



Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн он жилүүдэд хүн амын амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орж богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж байгааг дагалдан ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаарх бодит мэдээллийн хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байна.

Улс орнууд хүн амаа 10 жил тутам тоолж байх НҮБ-ын зөвлөмжийн дагуу 2010 онд дэлхийн 53, үүний дотор азийн 15 улс орон тооллого зохион байгуулсны нэг нь Монгол улс юм. Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг "Хүмүүнд төр эрхэм, төрд хүмүүн эрдэнэ" уриан дор 2010 оны 11 дүгээр сарын 11-нээс 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулан явууллаа. Монгол улсын түүхэнд 10 дахь удаагийн, XXI зууны анхны энэхүү тооллого нь өмнөх тооллогуудаас нэлээд онцлогтой болсон. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 15, түүнээс дээш насны бүх хүн амаас эдийн засгийн идэвхийн талаарх асуултуудыг асуусан бөгөөд тооллогын үр дүнгээр ажиллагчдыг эрхэлдэг ажил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдал болон бусад үзүүлэлтээр, ажилгүй иргэд, эдийн засгийн идэвхгүй хүн амыг ч мөн адил хүн ам зүйн болон боловсрол, гэрлэлт, шилжих хөдөлгөөний байдлаар засаг захиргааны бүх түвшинд гаргах боломжтой юм. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр олон төрлийн эмхтгэл, тусгайлсан сэдвээр товхимолуудыг бэлтгэн хэвлүүлж байгаагийн нэг болох "Эдийн засгийн идэвх" гэсэн энэхүү товхимолыг Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ





## 1.1 СУДАЛГААНЫ БҮТЭЦ, АГУУЛГА

Эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлт гэсэн энэхүү судалгаа 6 бүлэгтэй болно. Үүнд:

- 1-р бүлэгт судалгааны зорилго, ач холбогдол, ойлголт, тодорхойлолт, хүн ам зүйн болон эдийн засгийн идэвхийн байдал, тооллогын үр дүнг бусад эх үүсвэртэй харьцуулсан байдлыг,
- 2-р бүлэгт Монгол улсын эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн амыг хүйс, насны бүлгээр, ажиллах хүчний оролцооны түвшинг нас, хүйсийн ялгаатай байдал, хот, хөдөө, боловсролын түвшин, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, шилжих хөдөлгөөнөөр нь,
- 3-р бүлэгт ажил эрхэлж байгаа хүн амын бүтцийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын болон ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, боловсролын түвшингээр,
- 4-р бүлэгт ажил эрхлэхгүй байгаа хүн амыг хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, ажил эрхлэхгүй байгаа шалтгаанаар,
- 5-р бүлэгт эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн амыг бүс нутгийн болон аймгийн түвшинд харьцуулж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг,
- Энэхүү 1-5-р бүлэгт харуулсан судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, түүнийг бодлого боловсруулах болон ажиллах хүч, түүнтэй холбоотой асуудлаар хийгдэх дараа дараагийн судалгаануудад ашиглах санал, зөвлөмжийг тус тус тусгав.

## 1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр Монгол Улсын хүн амын эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийн тодорхой цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бүй болгох бүхий л түвшний хэрэглэгчдийг энэ чиглэлийн мэдээллээр хангахад оршино.

## 1.3 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХЭМЖИГДЭХҮҮН

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор НҮБ-ын “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”–ийн[1] 2.231-2.349 хэсгийг хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг тодорхойлж өмнөх тооллого болон бусад судалгааны үзүүлэлттэй харьцуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн Үндэсний Статистикийн Хороо, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2009 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 01-681/94 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг удирдамж болгосон юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 2000 оны адилаар эдийн засгийн тухайн үеийн идэвхийн аргачлалаар хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг тооцсон болно.

Үүнд:

1. **“Эдийн засгийн идэвхтэй хүн ам”**-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

---

[1] Нэмэлт оруулсан 2 дахь хэвлэл, НҮБ, Нью-Йорк, 2009 он

2. "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ын дагуу тооллого, судалгааны мэдээлэл цуглуулж буй тухайн цаг хугацаанаас өмнөх сүүлийн 7 хоногт ядаж нэг цаг цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг **"ажиллагч"** гэж үзнэ. Түүнчлэн өвчтэй болон гэмтсэний улмаас урт, богино хугацааны түр чөлөө авсан, жирэмсний болон төрсний дараах чөлөөтэй, ээлжийн амралттай, захиргааны түр чөлөөтэй (цалинтай, цалингүй), улирлын чанартай ажил, үйлдвэрлэл эрхэлдэг учраас өвлийн улиралд түр ажиллахгүй байгаа, аж ахуйн нэгж, байгууллага нь ямар нэг шалтгаанаар ажлаа зогсоосон, сургалтанд хамрагдсан болон тооллогын товын өмнөх 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй боловч үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй хүмүүсийг мөн хөдөлмөр эрхэлдэг гэж тодорхойлсон.
3. Тоологын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг ***"ажилгүй иргэд буюу ажил хайж байгаа"*** гэж үзсэн.
4. **"Эдийн засгийн идэвхгүй хүн ам"** нь эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны болон хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амаар тодорхойлогдоно. Үүнд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна.
5. **Үндсэн өрх.** Тухайн орон сууцанд ганц өрх амьдарч тохиолдолд "Үндсэн өрх" гэж ойлгоно.
6. **Хамт суудаг өрх.** Тухайн орон сууцанд амьдарч байгаа үндсэн өрхөөс бусад өрхийн хувьд тухайн орон сууцанд "Хамт суудаг өрх" гэж тодорхойлогдоно.
7. **Өрх үүсгээгүй хүмүүс.** Тооллогын үед хүн амьдарч байгаа бүх төрлийн сууц болох гэр, байшин, зориулалтын бус сууц болон бусад сууцанд суугаа өрх үүсгээгүй байна.

Хүн амын эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй ангилалд ХАОСТ-ын дараах асуулт, түүний хариултыг ашигласан байдлыг дараах зургаар үзүүлбэл:

## ЗУРАГ 1.1. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХОД ХЭРЭГЛЭСЭН АСУУЛТ, ХАОСТ- 2010




Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эдгээр асуултыг 15, түүнээс дээш насны бүх хүнээс товын өмнөх 7 хоногт цалин, хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон эсэхээр тодруулсан юм.

Зураг 2-оос харахад 2000 оны тооллогоор эдийн засгийн идэвхгүй хүн амыг 6 шалтгаанаар задлан гаргаж байсан бол 2010 оны тооллогоор 7 шалтгаанаар харууллаа. Энэ удаагийн тооллогоор “Ажиллах сонирхолгүй” гэсэн шалтгааныг нэмж асуусан юм. Энэ шалтгаанд “хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай боловч цалин, хөлстэй болон хувиараа хөдөлмөрлөж эдийн засгийн үйл ажиллагаанд ажиллах хүчээ нийлүүлэх сонирхолгүй хүнийг” ойлгох юм.

## ЗУРАГ 1.2. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ БАЙГААГИЙН ШАЛГААН, 2000, 2010 ОН

**2000 он**

1. Сургуульд сурдаг
2. Тэтгэвэр, нөхөн олговорт
3. Өвчтэй, тахир дутуугийн групп
4. Гэрийн ажилтай
5. Тохирох ажил олдохгүй байгаа
6. Бусад

**2010 он**

1. Сургуульд сурдаг
2. Тэтгэвэрт
3. Хөдөлмөр эрхлэх чадваргүй
4. Гэрийн ажилтай
5. Тохирох ажил олдохгүй байгаа
6. Ажиллах сонирхолгүй
7. Бусад

Сүүлийн 2 удаагийн тооллогын асуулгаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн ажил (байгууллагын)-ын үндсэн үйл ажиллагааны чиглэл (ЭЗБҮАСА) , эрхэлдэг ажлын төрөл буюу албан тушаал (АМА), хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус)-ын талаарх мэдээлэл цуглуулагдсан юм. Иймээс тухайн хүний ажилладаг байгууллагын эдийн засгийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал - (ISIC-4.0)”, эрхэлдэг ажлын төрлийг “Үндэсний ажил мэргэжлийн ангилал (ISCO-08)”–аар задалж гаргасан нь 2000 он болон 2010 оны тооллогын үр дүнг харьцуулах боломжийг олгож байна. Эдгээр ангиллын ялгаатай болон ижил төстэй байдлыг гурав, дөрөвдүгээр бүлгээс дэлгэрэнгүй харж болно.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын өөрчлөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйл, эдгээрийн өөрчлөлтийг тодорхойлохын тулд энэхүү судалгаанд хүн амын нас, хүйс, хот, хөдөөгийн суурьшил, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, хөгжлийн бэрхшээл, шилжих хөдөлгөөн зэрэг тооллогоор цуглуулсан мэдээллийг ашиглалаа.

Судалгаанд эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх дараах үндсэн хэмжигдэхүүнүүдийг хэрэглэсэн юм. Үүнд:

1. Ажиллах хүчний оролцооны түвшин. Эдийн засгийн идэвх (ажиллах хүч)-тэй хүн амыг 15 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулж оролцооны түвшинг тодорхойлно.
2. Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин. Тухайн насны бүлэг дэх эдийн засгийн идэвхтэй хүн амыг тухайн насны нийт хүн амд харьцуулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин. Ажил эрхэлдэг хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын харьцаа байна.
4. Ажилгүйдлийн түвшин. Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулна.

Дээр дурдсан аргачлалаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний оролцоо, ажилгүйдлийн түвшинг насны бүлэг, хүйс, аймаг, бүс нутаг, хот, хөдөөгөөр тодорхойллоо.

## 1.4 ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Улс орны хүн амын эдийн засгийн идэвхийн дүр төрхөд хөдөлмөрийн нийлүүлэлт, эрэлтийг тодорхойлж буй хүн ам зүйн байдал их нөлөөлдөг учраас эдийн засгийн идэвхийг судлахаасаа өмнө Монгол улсын хүн ам зүйн байдлыг товч танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

### ХҮН АМЫН ТОО, БАЙРШЛААР

Монгол Улсын суурин хүн амын тоо 2010 оны тооллогоор 2 754.7 мянга байна. Үүний 49.5 хувь эрэгтэйчүүд, 50.5 хувь эмэгтэйчүүд юм.

2010 оны ХАОСТ-оор Монгол Улсын 1км2 нутагт 1.7 хүн ногдож байгааг 2000 онтой харьцуулахад 0.2 пунктээр нэмэгдсэн хэдий ч хүн амын нягтрал ихээхэн сийрэг байна. Харин Улаанбаатар хотод 1км2 нутагт 245.6 хүн, Орхон аймагт 108.9 хүн, Дархан-Уул аймагт 27.5 хүн ногдож байгаа нь улсын дундажаас нилээд их байна. Үүний зэрэгцээ Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад хүн амын нягтрал 2000 оныхоос 0.1-0.3 пунктээр буурчээ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2000 онд нийт хүн амын 32.0 хувь оршин сууж байсан бол 2010 оны тооллогоор 43.6 хувь болж, 11.6 пунктээр нэмэгдсэн байна. Түүнчлэн Орхон, Өмнөговь аймгийн хүн амын эзлэх хувь 0.3 пунктээр, Дорноговь аймгийнх 0.1 пунктээр нэмэгдсэн боловч, бусад аймгуудын хувьд энэ хувь буурчээ. Энэ нь сүүлийн 10 жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нилээд нэмэгдэж, цаашдаа Орхон, Өмнөговь, Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байгаа юм.

ХҮСНЭГТ 1.1. ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2000, 2010 ОН

| Аймаг, нийслэл | 2000 | | | 2010 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мян.хүн | Дунд эзлэх хувь | Хүн/km$^2$ | Мян.хүн | Дунд эзлэх хувь | Хүн/km$^2$ |
| **БҮГД** | **2373.5** | **100** | **1.5** | **2647.5** | **100.0** | **1.7** |
| Архангай | 97.1 | 4.1 | 1.8 | 84.1 | 3.2 | 1.5 |
| Баян-Өлгий | 91.1 | 3.8 | 2.0 | 85.2 | 3.2 | 1.9 |
| Баянхонгор | 84.8 | 3.5 | 0.7 | 75.7 | 2.9 | 0.7 |
| Булган | 61.8 | 2.6 | 1.3 | 53.1 | 2.0 | 1.1 |
| Говь-Алтай | 63.7 | 2.7 | 0.5 | 53.2 | 2.0 | 0.4 |
| Дорноговь | 50.6 | 2.1 | 0.5 | 57.9 | 2.2 | 0.5 |
| Дорнод | 75.4 | 3.2 | 0.6 | 68.9 | 2.6 | 0.6 |
| Дундговь | 51.5 | 2.2 | 0.7 | 38.6 | 1.5 | 0.5 |
| Завхан | 90.0 | 3.8 | 1.1 | 64.9 | 2.4 | 0.8 |
| Өвөрхангай | 111.4 | 4.7 | 1.8 | 100.4 | 3.8 | 1.6 |
| Өмнөговь | 46.9 | 2.0 | 0.3 | 60.9 | 2.3 | 0.4 |
| Сүхбаатар | 56.2 | 2.4 | 0.7 | 51.1 | 1.9 | 0.6 |
| Сэлэнгэ | 100.0 | 4.2 | 2.4 | 95.8 | 3.6 | 2.3 |
| Төв | 99.3 | 4.2 | 1.3 | 83.8 | 3.2 | 1.1 |
| Увс | 90.0 | 3.8 | 1.3 | 72.9 | 2.7 | 1.0 |
| Ховд | 86.8 | 3.7 | 1.1 | 76.3 | 2.9 | 1.0 |
| Хөвсгөл | 119.1 | 5.0 | 1.2 | 114.3 | 4.3 | 1.1 |
| Хэнтий | 70.9 | 3.0 | 0.9 | 65.3 | 2.5 | 0.8 |
| Дархан-Уул | 83.3 | 3.5 | 25.4 | 90.6 | 3.4 | 27.5 |
| Улаанбаатар | 760.1 | 32.0 | 161.7 | 1154.3 | 43.6 | 245.6 |
| Орхон | 71.5 | 3.0 | 85.1 | 87.1 | 3.3 | 108.9 |
| Говьсүмбэр | 12.2 | 0.5 | 2.2 | 13.1 | 0.5 | 2.4 |

Манай улсын 713.8 мянган өрхөд 2553.8 мянган хүн амьдарч, өрхийн ам бүлийн дундаж тоо 3.4 байна. Харин өрх үүсгээгүй амьдарч байгаа 93.8 мянган хүн байна. Өрхийн тоог хэлбэрээр нь авч үзвэл ам бүлээрээ байгаа 445.0 мянган өрх 62.4 хувийг, нийлмэл 177.9 мянган өрх 24.9 хувийг, ганц бие 75.9 мянган өрх буюу 10.6 хувийг, холимог 14.9 мянган өрх 2.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.2-оос харахад 2010 онд нийт 713.8 мянган өрх тоологдсон нь 2000 оныхоос 31.9 хувиар, хотын өрхийн тоо 61.9 хувиар нэмэгдэж, харин хөдөөгийн өрхийн тоо 4.3 хувиар буурчээ.

### ХҮСНЭГТ 1.2. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

| Байршил | 2000 | | 2010 | | |
|---|---|---|---|---|---|
| | Өрхийн тоо | Дунд эзлэх хувь | Өрхийн тоо | Дунд эзлэх хувь | |
| **БҮГД** | **541.1** | **100.0** | **713.8** | **100.0** | **131.9** |
| Хот | 296.4 | 54.8 | 479.5 | 67.2 | 161.9 |
| Хөдөө | 244.7 | 45.2 | 234.3 | 32.8 | 95.7 |

## ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Тухайн орны ажиллах хүчний тоо хэмжээ, өсөлтөд хүн амын насны бүтэц ихээхэн нөлөөлдөг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг хүснэгт 1.3-д харуулав. Нийт хүн амд 20-24 насныхан 11.4 хувийг эзэлж байгаа нь бусад насны бүлгийнхээс хамгийн өндөр байгаа бөгөөд хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн 11.6 хувь, эмэгтэйчүүдийн 11.1 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна. Манай улсын хүн ам залуу насны бүтэцтэй өөрөөр хэлбэл 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь өндөр хэвээр байна. Төр, засгийн зүгээс хүүхэд, залуучуудад чиглэсэн боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүдийн цар хүрээг өргөтгөх нь урьдын адил чухлаар тавигдаж байна.

### ХҮСНЭГТ 1.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010 ОН

| Насны бүлэг | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | | Хүйсийн харьцаа[1] |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Дунд эзлэх хувь | Бүгд | Дунд эзлэх хувь | Бүгд | Дунд эзлэх хувь | |
| **БҮГД** | **2 754 685** | **100.0** | **1 363 923** | **100.0** | **1 390 762** | **100.0** | **98.1** |
| 0-4 | 293 096 | 10.6 | 148 825 | 10.9 | 144 271 | 10.4 | 103.2 |
| 5-9 | 219 384 | 8.0 | 111 712 | 8.2 | 107 672 | 7.7 | 103.8 |
| 10-14 | 240 398 | 8.7 | 121 834 | 8.9 | 118 564 | 8.6 | 102.8 |
| 15-19 | 266 821 | 9.7 | 134 980 | 9.9 | 131 841 | 9.5 | 102.4 |
| 20-24 | 312 583 | 11.4 | 157 636 | 11.6 | 154 947 | 11.1 | 101.7 |
| 25-29 | 268 721 | 9.8 | 134 651 | 9.9 | 134 070 | 9.6 | 100.4 |
| 30-34 | 239 380 | 8.7 | 119 477 | 8.7 | 119 903 | 8.6 | 99.6 |
| 35-39 | 215 726 | 7.8 | 106 616 | 7.8 | 109 110 | 7.9 | 97.7 |
| 40-44 | 187 197 | 6.8 | 91 653 | 6.7 | 95 544 | 6.9 | 95.9 |
| 45-49 | 162 924 | 5.9 | 79 103 | 5.8 | 83 821 | 6.0 | 94.4 |
| 50-54 | 123 965 | 4.5 | 58 751 | 4.3 | 65 214 | 4.7 | 90.1 |
| 55-59 | 72 698 | 2.6 | 33 653 | 2.5 | 39 045 | 2.8 | 86.2 |
| 60-64 | 49 757 | 1.8 | 22 223 | 1.6 | 27 534 | 2.0 | 80.7 |
| 65-69 | 38 394 | 1.4 | 17 316 | 1.3 | 21 078 | 1.5 | 82.2 |
| 70+ | 63 641 | 2.3 | 25 493 | 1.9 | 38 148 | 2.7 | 66.8 |

*[1] 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо*

Улсын дунджаар 100 эмэгтэйд 98 эрэгтэй ногдож байна. Хүйсийн харьцаа 25-29 наснаас доош бүлэгт 100-аас их, 30-34 наснаас дээш бүлэгт 100-аас бага, ялангуяа 70, түүнээс дээш насны бүлэгт хамгийн бага буюу 67 байна.

Зураг 1.3-т Хүн амын насны бүтцийг Хүн ам, орон сууцны сүүлийн 4 удаагийн тооллогын дүнгээр харуулав. 2010 онд нийт хүн амын 67.2 хувийг 15-59 нас буюу хөдөлмөрийн насны хүн ам, 27.3 хувийг 0-14 насны хүүхэд, 5.5 хувийг 60, түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Хүн амын насны бүтцэд сүүлийн 40 гаруй жилд гарсан өөрчлөлтөөс харахад хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж, харин 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь буурч байгаа хандлага ажиглагдлаа.

ЗУРАГ 1.3. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 1979, 1989, 2000, 2010 ОН




Сүүлийн тооллогын дүнгээр 60, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 5.5 хувь болж, 2000 оноос 2.0 пунктээр, 1989 оныхоос 1.5 пунктээр, 1979 оныхоос 0.5 пунктээр нэмэгдэв. Ахмад настны нийгмийн хамгааллын асуудал, тухайлбал тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээний хүрээ, чанар, санхүүжилт болон ажиллах хүчийг зөв зохистой байршуулах асуудалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

## ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулинд тэтгэврийн насыг эрэгтэйчүүдийн хувьд 60 нас, эмэгтэйчүүдийн хувьд 55 нас гэж заасан байдаг. Гэхдээ олон улсын түвшинд харьцуулагдахуйц байдлыг хангах үүднээс хүүхдэд 0-14 нас, өндөр настанд 65 ба түүнээс дээш насыг хамааруулж хүн ам зүйн ачааллыг тооцож байна.

Хүн ам зүйн ачааллыг 15 хүртэлх насны хүүхэд болон 65, түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 насны хүн амын тоонд харьцуулж гаргах бөгөөд 2010 оны тооллогоор энэ үзүүлэлт манай улсын хувьд 45 гарлаа.

### ХҮСНЭГТ 1.4. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, 1989, 2000, 2010 ОН

| | 1989 | 2000 | 2010 |
|---|---|---|---|
| **БҮГД** | **85** | **65** | **45** |
| Хүүхэд | 77 | 59 | 40 |
| Хөгшид | 8 | 6 | 5 |

Сүүлийн 3 удаагийн тооллогын үр дүнгээс харахад хүн ам зүйн ачаалал хурдтай буурч байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 15-64 насны 100 хүн тутамд 0-14 насны 40 хүүхэд, 65, түүнээс дээш насны 5 хүн ногдож байна.

### ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг эдийн засгийн идэвхтэй хүн ам (зарим тохиолдолд ажиллах хүч), эдийн засгийн идэвхгүй хүн ам гэсэн 2 ойлголтоор тодорхойлж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амд хөдөлмөр эрхэлж байгаа ажил эрхэлдэг хүн ам болон ажилгүй иргэдийг хамруулдаг учраас нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулагч нарт маш чухал үзүүлэлтэд тооцогддог. Өөрөөр хэлбэл эдийн засгийн идэвхтэй хүн ам тухайн үед ажиллаж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хүмүүсээс бүрдэнэ.

Зураг 1.4-өөс харахад 2010 оны тооллогоор Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 56.4 хувийг эдийн засгийн идэвхтэй буюу ажиллах хүчинд багтаж хүн ам эзэлж байгаа бөгөөд 2000 оныхоос түвшнээс 5.5 пунктээр буурсан байна.

### ЗУРАГ 1.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, 2000, 2010 ОН



Эдийн засгийн идэвхгүй хүн амын эзлэх хувийн жин 2000 онд 38.1 байсан бол 2010 онд 43.6 хувь болж нэмэгдсэн байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг бүрдүүлж байдаг сургуульд сурдаг хүн амын тоо 2000 оныхоос 129.5 мянга буюу 75.7 хувиар нэмэгджээ. Энэ үзүүлэлтийг нас, хүйс, байршил зэргээр тооцоход ялгаатай үр дүн гарна.

Нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь 25-29 насныханд бусад бүлгийн насныхнаас хамгийн өндөр хувьтай байна.

### ЗУРАГ 1.5. НИЙТ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН




Дээрх зургаас харахад 10 жилийн өмнө нийт хүн амд 10-14 насныхан дийлэнх хувийг эзэлж байсан бол 2010 онд энэ насныхан 20-24 насны бүлэгт шилжиж, мөн нийт хүн амын ихэнх хувийг эзэлж байна. 2000 онд 15-19 насны бүлэг дэх эдийн засгийн идэвхтэй хүн ам энэ насны бүлэг дэх хүн амын 41.2 хувийг эзэлж байсан бол 2010 онд 13.9 хувь болж 27.3 пунктээр багасав. 2010 онд 20-24 насны бүлэгт хамаарах нийт хүн амын тоо 2000 оныхоос 32.6 хувиар нэмэгдсэн байхад энэ насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1.1 хувиар нэмэгдсэн нь их, дээд сургуулиудын оюутны тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо өсөхийг хүн ам зүйн цонх нээгдэх гэж ойлгодог. Манай улсын хувьд нийт хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин 2000 онд 59.0 байсан бол 2010 оны тооллогоор 67.2 болж 8.2 пунктээр нэмэгдснийг хүн амын цонхны үе нээгдсэн гэж үзэж болохоор байна.

Хөгжлийн энэхүү таатай нөхцөл боломжийг үр өгөөжтэй ашиглах талаар зориудын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

## 1.5 АЖИЛЛАХ ХҮЧИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ

Зураг 1.6-д 2010 оны ХАОСТ-ын үр дүнгээр гарсан хүн амын насны бүлгээрх ажиллах хүчний оролцооны түвшинг 2000 оны тооллогын үр дүнтэй харьцуулж харуууллаа. 25-29 наснаас доош насны бүлэгт хүн амын ажиллах хүчний оролцоо доогуур байгаа нь эдгээр насны бүлэгт хамаарах хүн амын ихэнх нь суралцдаг гэсэн шалтгаанаар хөдөлмөр эрхлэхгүй буюу эдийн засгийн идэвхгүй байдагтай холбоотой юм. Хүн амын ихэнх нь буюу 70-80 хувь 25-44 насанд хөдөлмөр идэвхтэй эрхэлж байхад 45-59 насныхны эдийн засгийн идэвх аажмаар, 60-аас дээш насанд эрчимтэй буурч байгаа нь эдийн засгийн идэвхтэй хүн амын өсөлт, бууралтад хүн амын нас чухал үүрэг гүйцэтгэдгийг гэрчилж байна.

### ЗУРАГ 1.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2000, 2010 ОН




Зураг 1.7-аас харахад улсын хэмжээнд дээд боловсролтой хүн амын эдийн засгийн идэвх бусад боловсролын түвшинтэй хүн амынхаас өндөр байгаа нь дээд боловсролтой хүний нөөцийн хэрэгцээ шаардлага улам өсч байгааг харуулж байна.

### ЗУРАГ 1.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010 ОН



Хүснэгт 1.5-аас харахад хотын хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 52.3 хувь, хөдөөгийн хүн амынх 66.1 хувь байгаа нь 13.8 пунктээр илүү байна.

### ХҮСНЭГТ 1.5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

| Насны бүлэг | Улсын дүн | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2000 | 2010 | 2000 | 2010 | 2000 | 2010 |
| АХОТ | 61.9 | 56.4 | 53.8 | 52.3 | 73.6 | 66.1 |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 944 083 | 1 075 780 | 483 859 | 695 900 | 460 224 | 379 880 |
| 15 ба түүнээс дээш насны хүн ам | 1 524 372 | 1 905 969 | 898 676 | 1 331 679 | 625 696 | 574 290 |

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ БУЮУ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙДАЛ



## 2.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

2010 онд 15, түүнээс дээш насны 1906.0 мянган хүн тоологдсоны 1705.8 мянга нь эдийн засгийн идэвхтэй, үүнээс 911.7 мянган хүн тооллогын товын өмнөх 7 хоногт цалин, хөлс орлого олох зорилгоор дор хаяж нэг цаг хөдөлмөр эрхэлсэн, 164.1 мянган хүн ажилгүй гэж хариулсан байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам 830.2 мянгад хүрснийг 2000 оны тооллогынхтой харьцуулахад 43.1 хувиар буюу 249.9 мянган хүнээр нэмэгджээ (Хүснэгт 2.1).

### ХҮСНЭГТ 2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ , 2000, 2010 ОН

| | 2000 | 2010 | $\frac{2010}{2000}$ % |
|---|---|---|---|
| 15 ба түүнээс дээш насны хүн ам | 1 524 372 | 1 905 969 | 125.0 |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 944 083 | 1 075 780 | 113.9 |
| Ажил эрхэлдэг хүн ам | 779 151 | 911 664 | 117.0 |
| Ажилгүй иргэд | 164 932 | 164 116 | 99.5 |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 580 289 | 830 189 | 143.1 |
| Сургуульд сурдаг | 171 003 | 300 494 | 175.7 |
| Тэтгэвэрт | 163 666 | 191 907 | 117.3 |
| Хөдөлмөр эрхлэх чадваргүй | 36 912 | 55 888 | 151.4 |
| Гэрийн ажилтай | 76 307 | 108 403 | 142.1 |
| Тохирох ажил олдохгүй байгаа | 90 353 | 121 519 | 134.5 |
| Ажиллах сонирхолгүй | - | 3 283 | - |
| Бусад | 42 048 | 48 695 | 115.8 |

## 2.2 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМ

Монгол Улсын 2010 оны тооллогоор эдийн засгийн идэвхтэй 1075.8 мянган хүн байгаагийн 54.9 хувь буюу 590.1 мянга нь эрэгтэйчүүд, 45.1 хувь буюу 485.6 мянга нь эмэгтэйчүүд байна.

Хотод амьдарч буй эдийн засгийн идэвхтэй хүн ам 695.9 мянга байгаа нь хөдөөгийнхөөс 316.0 мянгаар илүү байв.

10 жилийн өмнө 10-14, 15-19 насны хүүхдүүд суурин хүн амын ихэнх хувийг эзэлж байсан (Бүлэг I-ийн зураг 1.5-аас харах) бол тэдгээр нь 2010 он гэхэд 20-24 нас, 25-29 насны бүлэгт шилжин орж, эдийн засгийн идэвхтэй хүн амын ихэнх хувийг бүрдүүлж байгааг Хүснэгт 2.2-т харуулав. Эдийн засгийн идэвхтэй хүн ам 30-49 нас хүртэл аажим, 50 наснаас эрчимтэй буурч байна. Энэ өөрчлөлт нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувьд адил байна.

### ХҮСНЭГТ 2.2. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

| Насны бүлэг | Улсын дүн | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **1 075 780** | **590 132** | **485 648** | **695 900** | **372 658** | **323 242** | **379 880** | **217 474** | **162 406** |
| 15-19 | 37 123 | 25 877 | 11 246 | 18 011 | 11 805 | 6 206 | 19 112 | 14 072 | 5 040 |
| 20-24 | 161 264 | 94 362 | 66 902 | 107 229 | 61 629 | 45 600 | 54 035 | 32 733 | 21 302 |
| 25-29 | 186 231 | 103 093 | 83 138 | 123 976 | 68 351 | 55 625 | 62 255 | 34 742 | 27 513 |
| 30-34 | 171 081 | 92 591 | 78 490 | 111 189 | 59 686 | 51 503 | 59 892 | 32 905 | 26 987 |
| 35-39 | 157 058 | 81 957 | 75 101 | 102 326 | 52 363 | 49 963 | 54 732 | 29 594 | 25 138 |
| 40-44 | 138 097 | 69 752 | 68 345 | 89 680 | 43 648 | 46 032 | 48 417 | 26 104 | 22 313 |
| 45-49 | 114 685 | 57 707 | 56 978 | 75 526 | 36 602 | 38 924 | 39 159 | 21 105 | 18 054 |
| 50-54 | 71 470 | 38 365 | 33 105 | 45 746 | 23 592 | 22 154 | 25 724 | 14 773 | 10 951 |
| 55-59 | 26 149 | 17 925 | 8 224 | 15 775 | 10 554 | 5 221 | 10 374 | 7 371 | 3 003 |
| 60-64 | 7 372 | 4 890 | 2 482 | 4 126 | 2 745 | 1 381 | 3 246 | 2 145 | 1 101 |
| 65+ | 5 250 | 3 613 | 1 637 | 2 316 | 1 683 | 633 | 2 934 | 1 930 | 1 004 |

Хот, суурин газарт 15-19 насны эдийн засгийн идэвхтэй хүн ам нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 2.6 хувийг эзэлж байхад хөдөө, орон нутагт энэ насны бүлгийнхэн 5.0 хувийг эзэлж байгаа нь хөдөөний ихэнх залуучууд ерөнхий боловсролын сургууль төгссөний дараа шууд хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой юм.

Хүснэгт 2.3-д эдийн засгийн идэвхтэй хүн амыг нийслэл, аймаг болон бүсээр үзүүллээ. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 42.0 хувь нь Улаанбаатар хотод, 20.5 хувь нь Хангайн бүсэд, 17.9 хувь нь Төвийн бүсэд, 12.5 хувь нь Баруун бүсэд, 7.1 хувь нь Зүүн бүсэд байна. Өвөрхангай, Хөвсгөл аймгуудын эдийн засгийн идэвхтэй ихтэй хүн амын тоо өндөр байгаа нь Хангайн бүсийн хүн амын эдийн засгийн идэвх өндөр байгаад нөлөөлж байна.

Өмнөговь аймагт эдийн засгийн идэвхтэй байгаа эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс даруй 88.0 хувиар, Баянхонгор аймагт 14.3 хувиар илүү дүр зураг харагдлаа.

## ХҮСНЭГТ 2.3 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМ, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2010 ОН.

| | Бүгд | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **УЛСЫН ДУНДАЖ** | **1 075 780** | **590 132** | **485 648** | **695 900** | **372 658** | **323 242** | **379 880** | **217 474** | **162 406** |
| **БАРУУН БҮС** | **134 019** | **74 306** | **59 713** | **41 980** | **22 002** | **19 978** | **92 039** | **52 304** | **39 735** |
| Баян-өлгий | 29 107 | 16 719 | 12 388 | 10 308 | 5 589 | 4 719 | 18 799 | 11 130 | 7 669 |
| Говь-Алтай | 22 701 | 12 400 | 10 301 | 6 563 | 3 372 | 3 191 | 16 138 | 9 028 | 7 110 |
| Завхан | 25 918 | 14 085 | 11 833 | 5 990 | 2 994 | 2 996 | 19 928 | 11 091 | 8 837 |
| Увс | 28 384 | 15 633 | 12 751 | 9 680 | 5 103 | 4 577 | 18 704 | 10 530 | 8 174 |
| Ховд | 27 909 | 15 469 | 12 440 | 9 439 | 4 944 | 4 495 | 18 470 | 10 525 | 7 945 |
| **ХАНГАЙН БҮС** | **220 594** | **119 329** | **101 265** | **87 285** | **45 920** | **41 365** | **133 309** | **73 409** | **59 900** |
| Архангай | 36 841 | 19 867 | 16 974 | 7 317 | 3 727 | 3 590 | 29 524 | 16 140 | 13 384 |
| Баянхонгор | 33 587 | 17 911 | 15 676 | 11 004 | 5 689 | 5 315 | 22 583 | 12 222 | 10 361 |
| Булган | 24 414 | 13 439 | 10 975 | 5 780 | 2 986 | 2 794 | 18 634 | 10 453 | 8 181 |
| Орхон | 35 897 | 19 357 | 16 540 | 34 550 | 18 585 | 15 965 | 1 347 | 772 | 575 |
| Өвөрхангай | 42 478 | 23 055 | 19 423 | 14 401 | 7 478 | 6 923 | 28 077 | 15 577 | 12 500 |
| Хөвсгөл | 47 377 | 25 700 | 21 677 | 14 233 | 7 455 | 6 778 | 33 144 | 18 245 | 14 899 |
| **ТӨВИЙН БҮС** | **193 044** | **110 983** | **82 061** | **83 772** | **45 315** | **38 457** | **109 272** | **65 668** | **43 604** |
| Говьсүмбэр | 5 704 | 3 163 | 2 541 | 4 215 | 2 254 | 1 961 | 1 489 | 909 | 580 |
| Дархан-Уул | 34 988 | 19 108 | 15 880 | 28 517 | 15 379 | 13 138 | 6 471 | 3 729 | 2 742 |
| Дорноговь | 26 087 | 14 751 | 11 336 | 14 336 | 8 003 | 6 333 | 11 751 | 6 748 | 5 003 |
| Дундговь | 17 393 | 9 328 | 8 065 | 5 493 | 2 855 | 2 638 | 11 900 | 6 473 | 5 427 |
| Өмнөговь | 33 794 | 22 061 | 11 733 | 7 789 | 4 165 | 3 624 | 26 005 | 17 896 | 8 109 |
| Сэлэнгэ | 39 101 | 21 923 | 17 178 | 18 382 | 9 986 | 8 396 | 20 719 | 11 937 | 8 782 |
| Төв | 35 977 | 20 649 | 15 328 | 5 040 | 2 673 | 2 367 | 30 937 | 17 976 | 12 961 |
| **ЗҮҮН БҮС** | **75 868** | **42 306** | **33 562** | **30 608** | **16 213** | **14 395** | **45 260** | **26 093** | **19 167** |
| Дорнод | 26 098 | 14 655 | 11 443 | 12 841 | 6 677 | 6 164 | 13 257 | 7 978 | 5 279 |
| Сүхбаатар | 22 952 | 12 808 | 10 144 | 6 544 | 3 597 | 2 947 | 16 408 | 9 211 | 7 197 |
| Хэнтий | 26 818 | 14 843 | 11 975 | 11 223 | 5 939 | 5 284 | 15 595 | 8 904 | 6 691 |
| **УЛААНБААТАР** | | | | | | | | | |
| Улаанбаатар | 452 255 | 243 208 | 209 047 | 452 255 | 243 208 | 209 047 | - | - | - |

Сүүлчийн 10 жилд хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал аймаг, нийслэлд хэрхэн өөрчлөгдснийг хавсралт 1-ийн хүснэгт 1-ээс үзнэ үү. Улаанбаатар хотод эдийн засгийн идэвхтэй хүн ам 64.4 хувиар, Өмнөговь аймагт 50.8 хувиар, Орхон аймагт 26.8 хувиар, Говьсүмбэр аймагт 25.3 хувиар, Дархан-Уул 17.6 хувиар, Дорноговь аймагт 13.2 хувиар, Сэлэнгэ аймагт 9.0 хувиар нэмэгдэж, харин бусад аймагт буурав.

Арван тав, түүнээс дээш насны ямар нэгэн боловсрол эзэмшсэн 1824.3 мянган хүний 56.9 хувь нь, харин боловсролгүй 81.7 мянган хүний 46.1 хувь нь эдийн засгийн идэвхтэй байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 96.5 хувь нь боловсролтой, үүний дотор 34.3 хувь нь бүрэн дунд, 28.4 хувь нь дээд, 17.4 хувь нь суурь, 8.8 хувь нь бага, 7.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.9 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүн байна. Харин эдийн засгийн идэвхтэй хүн амын 3.5 хувийг боловсролгүй хүн ам эзэлж, үүнээс 68.3 хувь нь бичиг үсэг мэддэг, 31.7 хувь нь бичиг үсэг мэддэгүй гэж хариулжээ (Хавсралт 1-ийн хүснэгт 1).

Зураг 2.1-д эдийн засгийн идэвхтэй хүн амд боловсролтой, боловсролгүй эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувийн жинг сүүлчийн 2 тооллогын дүнгээр харууллаа. 2010 оны тооллогоор боловсролтой эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь 96.5 болж 2000 оныхоос 0.2 пунктээр нэмэгдсэн байна. 2010 оны тооллогын дүнгээр боловсролтой эдийн засгийн идэвхтэй хүн ам 1038.2[2] мянгад хүрч 2000 оныхоос 129.5 мянга буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна.

[2] Хавсралт 1-ийн хүснэгт 1

ЗУРАГ 2.1 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМД БОЛОВСРОЛТОЙ, БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010 ОН.




## 2.3 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Эдийн засгийн идэвхтэй байдлыг илүү тодорхой илэрхийлэх хэмжүүр бол ажиллах хүчний оролцооны түвшин юм. Энэхүү үзүүлэлт нь 2010 онд 56.4 хувь болж ь 2000 оныхоос 5.5 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 2.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, 2000, 2010 ОН.

| | 2000 | 2010 | 2010/2000 % |
|---|---|---|---|
| 15, түүнээс дээш насны хүн ам | 1 524 372 | 1 905 969 | 125.0 |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 944 083 | 1 075 780 | 113.9 |
| Ажиллах хүчний оролцооны түвшин | 61.9 | 56.4 | |

## 2.4 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАС, ХҮЙСЭЭР

Ажиллах хүчний оролцооны түвшинг нас, хүйсээр, сүүлчийн 2 удаагийн тооллогын үр дүнгээр хүснэгт 2.5-д харууллаа. 2000 онд 15-19 насны бүлгийн ажиллах хүчний оролцооны түвшин 41.2 хувь байсан бол 2010 онд 14.4 хувь болж 26.8 пунктээр буурсан нь бусад насны бүлгийнхээс онцлогтой байна. Мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин энэ насны бүлэгт эрс буурчээ. Манай улсын хувьд сүүлийн 10 жилд хувийн хэвшлийн ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежууд олноороо байгуулагдаж, түүнд суралцагчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Зах зээлийн шилжилтийн үед сургууль завсардалт ихтэй, хүүхэд залуучуудын хөдөлмөр эрхлэлт их байсан бол сүүлийн жилүүдэд 15-19 насны бүлгийн хүүхэд, залуучуудын дийлэнх нь сургуульд суралцаж (15-19 насны 201.3 мянган хүн сургуульд хамрагдсан нь 2000 оныхоос 61.6 хувиар нэмэгдсэн) байгаагаас хөдөлмөр эрхлэх нь багассан гэж дүгнэж болно.

## ХҮСНЭГТ 2.5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН.

| Насны бүлэг | Бүгд | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2000 | 2010 | 2000 | 2010 | 2000 | 2010 |
| **БҮГД** | **61.9** | **56.4** | **53.8** | **52.3** | **73.6** | **66.1** |
| 15-19 | 41.2 | 14.4 | 23.9 | 9.6 | 65.8 | 27.6 |
| 20-24 | 67.7 | 55.2 | 53.5 | 48.3 | 87.0 | 76.8 |
| 25-29 | 75.7 | 75.1 | 67.2 | 72.2 | 87.3 | 81.6 |
| 30-34 | 77.4 | 76.9 | 72.0 | 74.4 | 85.5 | 82.0 |
| 35-39 | 79.0 | 77.6 | 75.4 | 75.2 | 85.2 | 82.5 |
| 40-44 | 78.8 | 77.0 | 75.2 | 74.7 | 84.8 | 81.8 |
| 45-49 | 70.8 | 72.2 | 66.8 | 69.5 | 77.1 | 78.3 |
| 50-54 | 56.4 | 58.5 | 51.3 | 55.1 | 64.3 | 66.0 |
| 55-59 | 41.8 | 36.3 | 33.7 | 32.0 | 51.4 | 45.8 |
| 60-64 | 19.5 | 14.9 | 12.9 | 11.9 | 26.5 | 22.0 |
| 65+ | 8.6 | 5.2 | 4.0 | 3.4 | 13.8 | 8.8 |

2000 онд 35-39 насны бүлгийн хүн амын эдийн засгийн идэвх хамгийн өндөр буюу 79.0 хувь байсан бөгөөд 2010 онд мөн хамгийн өндөр буюу 77.6 хувь болов.

Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15-19 насанд харьцангуй доогуур байснаа 25-44 насанд хамгийн өндөр болж, 55 нас хүртэл аажим, түүнээс дээш насанд илүү хурдан буурч байна.

Бүх насны бүлэг дэх эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. Эдийн засгийн хүчин зүйлээс гадна хүн ам зүйн (гэрлэлтийн нас, хүүхдийн тоо) болон нийгэм, соёлын хүчин зүйлсээс шалтгаалж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт бага байдаг.

## ЗУРАГ 2.2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 35-39 насанд хамгийн өндөр буюу 77.6 хувь байгаа бөгөөд ихэнх аймагт мөн энэ насны бүлэгт ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа юм. Өмнөговь аймгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин бүх насны бүлэгт бусад аймгуудаас харьцангуй өндөр байна.

Зураг 2.2-ээс харахад 40-44 настай эмэгтэйчүүдийн оролцооны түвшин бусад насныхнаас өндөр, эрэгтэйчүүдийн хувьд 25-29 насанд хамгийн өндөр буюу 82.8 хувь байна.

## ХҮСНЭГТ 2.6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

| Аймаг, нийслэл | Бүгд | 15-19 | 20-24 | 25-29 | 30-34 | 35-39 | 40-44 | 45-49 | 50-54 | 55-59 | 60-64 | 65+ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **УЛСЫН ДҮН** | **56.4** | **14.4** | **55.2** | **75.1** | **76.9** | **77.6** | **77.0** | **72.2** | **58.5** | **36.3** | **14.9** | **5.2** |
| Архангай | 63.9 | 22.7 | 67.7 | 83.7 | 85.1 | 84.4 | 83.4 | 78.5 | 65.5 | 43.0 | 18.5 | 8.5 |
| Баян-өлгий | 54.2 | 13.5 | 61.9 | 74.5 | 74.6 | 73.6 | 74.3 | 69.8 | 56.6 | 33.8 | 8.8 | 1.7 |
| Баянхонгор | 65.2 | 27.2 | 75.6 | 80.9 | 82.0 | 82.0 | 81.6 | 78.3 | 66.2 | 45.4 | 20.6 | 9.2 |
| Булган | 65.3 | 21.5 | 75.7 | 82.9 | 84.5 | 84.0 | 81.9 | 78.0 | 66.5 | 47.2 | 22.5 | 7.4 |
| Говь-Алтай | 62.4 | 17.0 | 62.5 | 78.4 | 79.5 | 80.2 | 80.0 | 79.3 | 71.3 | 48.6 | 22.7 | 10.2 |
| Дорноговь | 63.9 | 21.2 | 67.4 | 80.2 | 80.7 | 82.8 | 78.9 | 75.0 | 60.9 | 41.2 | 22.3 | 5.7 |
| Дорнод | 53.3 | 18.3 | 64.0 | 71.3 | 72.0 | 69.5 | 66.7 | 62.1 | 46.6 | 29.5 | 13.0 | 2.6 |
| Дундговь | 65.8 | 20.1 | 78.5 | 85.0 | 84.8 | 85.8 | 85.2 | 82.2 | 68.1 | 50.6 | 22.4 | 8.2 |
| Завхан | 58.8 | 15.6 | 67.9 | 77.4 | 76.1 | 76.8 | 76.7 | 74.9 | 60.0 | 36.0 | 15.4 | 5.8 |
| Өвөрхангай | 62.1 | 23.0 | 74.1 | 79.8 | 79.7 | 80.7 | 78.7 | 75.1 | 61.6 | 40.9 | 18.3 | 7.4 |
| Өмнөговь | 74.7 | 32.1 | 83.8 | 87.5 | 88.3 | 89.1 | 87.5 | 83.7 | 72.9 | 55.2 | 31.2 | 11.3 |
| Сүхбаатар | 63.6 | 29.5 | 76.4 | 81.1 | 79.4 | 80.4 | 77.3 | 71.1 | 59.0 | 39.6 | 18.6 | 4.8 |
| Сэлэнгэ | 57.7 | 17.5 | 63.0 | 74.3 | 75.4 | 75.7 | 74.8 | 70.2 | 55.6 | 33.1 | 15.1 | 6.3 |
| Төв | 60.3 | 19.2 | 64.4 | 75.4 | 78.3 | 78.9 | 78.5 | 76.2 | 65.9 | 46.3 | 22.9 | 8.9 |
| Увс | 60.4 | 16.5 | 74.2 | 78.5 | 78.7 | 79.9 | 79.1 | 76.3 | 61.6 | 41.6 | 15.1 | 5.9 |
| Ховд | 55.9 | 13.5 | 57.7 | 76.1 | 76.5 | 77.3 | 78.2 | 73.2 | 58.1 | 39.5 | 13.0 | 3.7 |
| Хөвсгөл | 60.1 | 23.5 | 71.9 | 76.0 | 76.1 | 76.9 | 76.5 | 72.1 | 57.7 | 37.4 | 14.1 | 5.2 |
| Хэнтий | 59.6 | 21.8 | 69.8 | 75.7 | 76.5 | 76.4 | 75.0 | 70.6 | 59.5 | 39.9 | 21.4 | 8.1 |
| Дархан-Уул | 52.5 | 8.9 | 46.0 | 72.6 | 76.5 | 77.8 | 78.5 | 73.9 | 55.7 | 30.6 | 11.1 | 3.4 |
| Улаанбаатар | 51.9 | 9.3 | 45.7 | 72.0 | 74.6 | 75.5 | 75.3 | 69.7 | 55.6 | 31.8 | 12.0 | 3.4 |
| Орхон | 56.5 | 12.0 | 55.6 | 72.9 | 75.2 | 76.9 | 76.4 | 71.0 | 60.0 | 36.1 | 13.3 | 4.9 |
| Говьсүмбэр | 62.7 | 12.7 | 67.2 | 81.3 | 82.4 | 82.0 | 85.1 | 76.8 | 61.6 | 39.8 | 20.3 | 9.6 |

## ХҮСНЭГТ 2.7 ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН.

| Аймаг, нийслэл | Бүгд | 15-19 | 20-24 | 25-29 | 30-34 | 35-39 | 40-44 | 45-49 | 50-54 | 55-59 | 60-64 | 65+ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **УЛСЫН ДҮН** | **63.0** | **19.8** | **64.0** | **82.8** | **82.7** | **81.3** | **79.0** | **74.5** | **66.1** | **53.7** | **22.1** | **8.5** |
| Архангай | 69.5 | 32.9 | 78.7 | 86.2 | 87.2 | 85.1 | 84.5 | 79.7 | 71.8 | 60.2 | 25.4 | 12.6 |
| Баян-өлгий | 62.5 | 18.7 | 70.7 | 81.4 | 83.4 | 81.5 | 82.2 | 78.9 | 71.3 | 59.4 | 15.9 | 3.0 |
| Баянхонгор | 69.5 | 35.3 | 79.8 | 82.1 | 83.3 | 83.2 | 82.3 | 80.8 | 73.7 | 66.5 | 27.1 | 13.4 |
| Булган | 69.7 | 29.9 | 81.9 | 85.4 | 85.9 | 85.8 | 82.2 | 78.8 | 73.6 | 62.7 | 31.7 | 12.1 |
| Говь-Алтай | 68.7 | 24.5 | 72.2 | 82.1 | 83.6 | 82.3 | 81.0 | 80.0 | 77.4 | 68.3 | 33.5 | 17.3 |
| Дорноговь | 71.3 | 28.7 | 79.8 | 86.7 | 86.5 | 85.4 | 80.3 | 75.3 | 69.7 | 56.6 | 27.2 | 9.3 |
| Дорнод | 59.5 | 24.5 | 74.1 | 76.4 | 75.1 | 72.4 | 68.0 | 63.6 | 53.5 | 45.6 | 20.1 | 4.5 |
| Дундговь | 69.8 | 28.0 | 83.4 | 87.1 | 86.0 | 86.2 | 85.2 | 82.5 | 75.7 | 69.3 | 27.5 | 11.0 |
| Завхан | 64.3 | 22.2 | 74.3 | 80.9 | 80.0 | 79.0 | 78.9 | 76.5 | 70.2 | 59.1 | 24.6 | 10.2 |
| Өвөрхангай | 67.9 | 30.8 | 80.8 | 84.3 | 82.9 | 83.3 | 80.6 | 78.3 | 70.4 | 62.7 | 26.4 | 11.5 |
| Өмнөговь | 81.9 | 40.3 | 90.9 | 92.9 | 91.4 | 91.8 | 90.0 | 86.8 | 80.9 | 74.0 | 42.8 | 17.0 |
| Сүхбаатар | 69.6 | 37.9 | 82.6 | 83.9 | 81.9 | 82.3 | 78.9 | 73.1 | 67.3 | 57.6 | 28.3 | 8.5 |
| Сэлэнгэ | 63.5 | 23.6 | 71.1 | 81.4 | 80.3 | 78.9 | 76.9 | 71.9 | 64.0 | 48.2 | 21.1 | 9.1 |
| Төв | 66.0 | 26.7 | 73.1 | 81.1 | 81.1 | 80.5 | 79.3 | 78.1 | 73.8 | 65.8 | 31.5 | 13.5 |
| Увс | 66.1 | 24.6 | 77.8 | 81.7 | 81.9 | 83.0 | 81.2 | 77.7 | 72.6 | 62.0 | 23.7 | 9.8 |
| Ховд | 62.8 | 20.3 | 67.6 | 80.9 | 80.3 | 80.8 | 80.9 | 75.4 | 70.2 | 63.3 | 22.1 | 6.2 |
| Хөвсгөл | 65.8 | 30.4 | 77.4 | 80.7 | 79.8 | 78.4 | 78.1 | 74.4 | 68.0 | 57.9 | 20.6 | 8.2 |
| Хэнтий | 64.8 | 29.0 | 78.4 | 80.7 | 79.9 | 77.5 | 74.5 | 72.2 | 64.5 | 56.6 | 29.8 | 12.8 |
| Дархан-Уул | 59.0 | 12.6 | 56.2 | 82.8 | 84.4 | 81.8 | 81.2 | 76.5 | 64.1 | 45.6 | 16.9 | 4.9 |
| Улаанбаатар | 58.6 | 12.3 | 54.0 | 82.5 | 82.6 | 80.4 | 77.1 | 71.6 | 61.6 | 47.0 | 18.5 | 6.3 |
| Орхон | 62.8 | 15.7 | 65.3 | 83.7 | 82.2 | 81.6 | 79.2 | 74.3 | 65.7 | 50.6 | 17.4 | 7.1 |
| Говьсүмбэр | 67.3 | 15.2 | 74.1 | 87.4 | 86.8 | 85.4 | 87.0 | 78.4 | 70.7 | 57.1 | 28.7 | 14.8 |

## ХҮСНЭГТ 2.8 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН.

| Аймаг, нийслэл | Бүгд | 15-19 | 20-24 | 25-29 | 30-34 | 35-39 | 40-44 | 45-49 | 50-54 | 55-59 | 60-64 | 65+ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **УЛСЫН ДҮН** | **50.1** | **8.8** | **46.2** | **67.3** | **71.0** | **73.9** | **75.1** | **70.1** | **51.7** | **21.3** | **9.1** | **2.8** |
| Архангай | 58.4 | 12.3 | 56.7 | 81.3 | 83.1 | 83.8 | 82.4 | 77.1 | 59.6 | 27.3 | 12.6 | 5.1 |
| Баян-өлгий | 46.0 | 8.2 | 52.7 | 67.3 | 65.8 | 66.0 | 66.4 | 61.1 | 42.5 | 11.7 | 2.3 | 0.6 |
| Баянхонгор | 60.8 | 17.8 | 70.8 | 79.6 | 80.7 | 80.9 | 80.8 | 75.9 | 59.5 | 27.8 | 15.6 | 6.1 |
| Булган | 60.7 | 10.9 | 68.4 | 80.3 | 83.0 | 82.0 | 81.6 | 77.0 | 59.3 | 31.4 | 13.3 | 3.5 |
| Говь-Алтай | 56.1 | 9.5 | 52.2 | 74.4 | 75.0 | 78.0 | 78.9 | 78.6 | 65.5 | 31.8 | 15.7 | 5.8 |
| Дорноговь | 56.4 | 13.7 | 54.1 | 72.5 | 74.5 | 80.0 | 77.4 | 74.8 | 52.2 | 25.9 | 17.7 | 3.5 |
| Дорнод | 47.0 | 11.5 | 52.4 | 65.9 | 68.6 | 66.7 | 65.4 | 60.5 | 40.0 | 14.1 | 6.5 | 1.4 |
| Дундговь | 61.7 | 10.9 | 72.8 | 82.8 | 83.6 | 85.5 | 85.2 | 82.0 | 61.0 | 34.3 | 17.8 | 5.9 |
| Завхан | 53.4 | 8.1 | 60.6 | 74.0 | 72.3 | 74.6 | 74.5 | 73.3 | 50.5 | 17.5 | 8.6 | 2.3 |
| Өвөрхангай | 56.3 | 14.3 | 66.8 | 75.2 | 76.6 | 78.2 | 76.8 | 71.9 | 53.8 | 20.9 | 11.4 | 4.3 |
| Өмнөговь | 64.1 | 21.7 | 71.7 | 79.4 | 83.2 | 84.5 | 83.3 | 78.9 | 62.0 | 35.9 | 18.8 | 7.4 |
| Сүхбаатар | 57.4 | 19.4 | 69.4 | 78.0 | 76.7 | 78.3 | 75.7 | 69.1 | 50.9 | 23.5 | 10.3 | 2.8 |
| Сэлэнгэ | 51.6 | 10.3 | 53.2 | 66.5 | 70.1 | 72.5 | 72.9 | 68.4 | 47.9 | 18.2 | 9.6 | 4.1 |
| Төв | 54.0 | 9.8 | 53.0 | 68.9 | 75.2 | 77.1 | 77.6 | 74.3 | 58.1 | 26.2 | 14.2 | 4.9 |
| Увс | 54.7 | 7.8 | 69.8 | 75.1 | 75.4 | 76.8 | 77.0 | 75.0 | 50.7 | 22.4 | 9.3 | 3.3 |
| Ховд | 49.1 | 6.7 | 47.6 | 71.0 | 72.7 | 73.9 | 75.6 | 71.0 | 46.6 | 18.2 | 6.0 | 2.0 |
| Хөвсгөл | 54.6 | 15.8 | 65.9 | 71.1 | 72.4 | 75.4 | 74.9 | 69.9 | 48.2 | 20.0 | 9.3 | 3.2 |
| Хэнтий | 54.3 | 13.0 | 59.9 | 70.2 | 72.9 | 75.5 | 75.4 | 68.9 | 54.3 | 24.2 | 13.6 | 4.9 |
| Дархан-Уул | 46.4 | 5.0 | 35.7 | 62.5 | 68.6 | 74.1 | 76.1 | 71.8 | 48.5 | 17.8 | 6.4 | 2.3 |
| Улаанбаатар | 45.8 | 6.4 | 37.9 | 62.2 | 66.9 | 70.9 | 73.6 | 68.0 | 50.5 | 19.6 | 7.0 | 1.4 |
| Орхон | 50.6 | 8.1 | 45.8 | 62.4 | 68.3 | 72.6 | 73.9 | 68.2 | 54.4 | 22.3 | 10.1 | 3.5 |
| Говьсүмбэр | 57.8 | 9.1 | 58.8 | 74.8 | 78.0 | 78.3 | 83.3 | 75.1 | 52.0 | 24.7 | 12.7 | 5.6 |

Өмнөговь аймагт 35-39 насныхны ажиллах хүчний оролцооны түвшин бусад аймгийн энэ насны хүн амынхаас өндөр байна.

## 2.5 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР

Хэдийгээр хүн амын эдийн засгийн идэвхийн байдал хүйс, насны бүлгээр хот, хөдөөд ялгаа багатай, харин ажиллах хүчний оролцоо нилээд ялгаатай байгааг хүснэгт 2.9-т харуулав. 15, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 56.4 хувь байгаагаас хөдөөд нилээд өндөр буюу 66.1 хувьтай, харин хотод 52.3 хувь болж хөдөөгөөс нилээд доогуур байна. Хөдөөд ажиллах хүчний оролцооны түвшин ийнхүү өндөр байгаа нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт хөдөөгийн ажил эрхэлдэг хүн ам хамгийн өндөр хувийг (90.3) эзэлж байгаатай холбоотой юм.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад хотын ажиллах хүчний оролцооны түвшин 1.5 пунктээр, хөдөөгийнх 7.5 пунктээр буурсан нь улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин буурахад нөлөөлж байгаа юм. Энэ үзүүлэлт хотод нь 25-34 насанд 2.4-5.0 пунктээр, 45-54 насанд 2.7-3.8 пунктээр, хөдөөд 45-54 насанд 1.2-1.7 пунктээр нэмэгдсэн байхад бусад насны бүлэг тус бүрт буурсан байна.

### ХҮСНЭГТ 2.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

| Насны бүлэг | Бүгд | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2000 | 2010 | 2000 | 2010 | 2000 | 2010 |
| Бүгд | 61.9 | 56.4 | 53.8 | 52.3 | 73.6 | 66.1 |
| 15-19 | 41.2 | 14.4 | 23.9 | 9.6 | 65.8 | 27.6 |
| 20-24 | 67.7 | 55.2 | 53.5 | 48.3 | 87.0 | 76.8 |
| 25-29 | 75.7 | 75.1 | 67.2 | 72.2 | 87.3 | 81.6 |
| 30-34 | 77.4 | 76.9 | 72.0 | 74.4 | 85.5 | 82.0 |
| 35-39 | 79.0 | 77.6 | 75.4 | 75.2 | 85.2 | 82.5 |
| 40-44 | 78.8 | 77.0 | 75.2 | 74.7 | 84.8 | 81.8 |
| 45-49 | 70.8 | 72.2 | 66.8 | 69.5 | 77.1 | 78.3 |
| 50-54 | 56.4 | 58.5 | 51.3 | 55.1 | 64.3 | 66.0 |
| 55-59 | 41.8 | 36.3 | 33.7 | 32.0 | 51.4 | 45.8 |
| 60-64 | 19.5 | 14.9 | 12.9 | 11.9 | 26.5 | 22.0 |
| 65+ | 8.6 | 5.2 | 4.0 | 3.4 | 13.8 | 8.8 |

Өмнөговь аймагт 15, түүнээс дээш насны 100 хүн тутмын 75 нь хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хайж байгаа хүмүүс байхад Дархан-Уул, Дорнод, Баян-Өлгий, Ховд аймаг болон Улаанбаатар хотод 52-56, Орхон, Сэлэнгэ, Завхан, Хэнтий аймагт 57-60, Хөвсгөл, Төв, Увс, Өвөрхангай, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Архангай, Сүхбаатар, Дорноговь, Баянхонгор, Булган аймагт 61-65 хүн байна (Хүснэгт 2.10).

Увс, Өвөрхангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар, Архангай, Дорноговь, Баянхонгор, Булган, Дундговь аймгийн АХОТ улсын дунджаас 4.0-9.4 пунктээр илүү, харин Ховд, Баян-Өлгий, Дорнод, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотод 0.6-4.6 пунктээр бага байв.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцоог аймгаар авч үзэхэд Баянхонгор, Дундговь аймагт бага зөрүүтэй байхад Өмнөговь, Баян-Өлгий, Дорноговь аймагт нилээд зөрүүтэй байна.

## ХҮСНЭГТ 2.10. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, АЙМГААР, 2010 ОН.

| | Бүгд | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **УЛСЫН ДҮН** | **56.4** | **63.0** | **50.1** | **52.3** | **58.5** | **46.5** | **66.1** | **72.4** | **59.3** |
| Архангай | 63.9 | 69.5 | 58.4 | 48.6 | 54.7 | 43.5 | 69.3 | 74.1 | 64.3 |
| Баян-Өлгий | 54.2 | 62.5 | 46.0 | 50.9 | 56.9 | 45.2 | 56.2 | 65.7 | 46.4 |
| Баянхонгор | 65.2 | 69.5 | 60.8 | 52.5 | 56.3 | 48.9 | 73.9 | 78.0 | 69.6 |
| Булган | 65.3 | 69.7 | 60.7 | 55.9 | 57.9 | 54.0 | 68.9 | 74.0 | 63.4 |
| Говь-Алтай | 62.4 | 68.7 | 56.1 | 50.8 | 56.8 | 45.7 | 68.8 | 74.6 | 62.5 |
| Дорноговь | 63.9 | 71.3 | 56.4 | 59.1 | 67.3 | 51.3 | 71.0 | 76.6 | 64.5 |
| Дорнод | 53.3 | 59.5 | 47.0 | 46.6 | 51.0 | 42.6 | 61.9 | 69.0 | 53.5 |
| Дундговь | 65.8 | 69.8 | 61.7 | 56.8 | 59.7 | 54.0 | 71.0 | 75.5 | 66.3 |
| Завхан | 58.8 | 64.3 | 53.4 | 48.2 | 50.8 | 45.8 | 63.0 | 69.3 | 56.6 |
| Өвөрхангай | 62.1 | 67.9 | 56.3 | 53.9 | 58.5 | 49.6 | 67.3 | 73.5 | 61.0 |
| Өмнөговь | 74.7 | 81.9 | 64.1 | 58.4 | 62.8 | 54.0 | 81.6 | 88.2 | 70.0 |
| Сүхбаатар | 63.6 | 69.6 | 57.4 | 55.0 | 60.9 | 49.2 | 67.9 | 73.8 | 61.6 |
| Сэлэнгэ | 57.7 | 63.5 | 51.6 | 54.3 | 59.8 | 48.9 | 61.1 | 67.0 | 54.5 |
| Төв | 60.3 | 66.0 | 54.0 | 51.1 | 55.6 | 46.8 | 62.1 | 67.8 | 55.6 |
| Увс | 60.4 | 66.1 | 54.7 | 52.5 | 57.1 | 48.2 | 65.5 | 71.6 | 59.1 |
| Ховд | 55.9 | 62.8 | 49.1 | 46.7 | 52.6 | 41.6 | 62.1 | 69.1 | 54.7 |
| Хөвсгөл | 60.1 | 65.8 | 54.6 | 52.3 | 57.0 | 47.9 | 64.3 | 70.1 | 58.3 |
| Хэнтий | 59.6 | 64.8 | 54.3 | 53.8 | 57.9 | 49.8 | 64.7 | 70.4 | 58.4 |
| Дархан-Уул | 52.5 | 59.0 | 46.4 | 51.2 | 57.4 | 45.5 | 59.0 | 66.6 | 51.0 |
| Улаанбаатар | 51.9 | 58.6 | 45.8 | 51.9 | 58.6 | 45.8 | - | - | - |
| Орхон | 56.5 | 62.8 | 50.6 | 56.2 | 62.5 | 50.4 | 64.4 | 71.5 | 56.8 |
| Говьсүмбэр | 62.7 | 67.3 | 57.8 | 61.9 | 64.5 | 59.2 | 65.1 | 75.6 | 53.4 |

Зураг 2.3-аас харахад Хангайн бүсийн хүн амын эдийн засгийн идэвх 61.7 хувь байгаа нь бусад бүсийнх 0.5-9.8 пунктээр илүү байна.

Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо аль ч бүсийн хувьд улсын дундаж болон эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр, Төвийн бүсэд 67.7 хувь буюу хамгийн их, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 58.6 хувь байна.

## ЗУРАГ 2.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БҮС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН.



## 2.6 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР

Хүснэгт 2.11-д ажиллах хүчний оролцооны түвшинг боловсролын түвшин, хүйс, хот, хөдөөгөөр харуулав. Улсын хэмжээнд боловсролтой эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин боловсролтой эмэгтэйчүүдийнхээс 12.3 хувиар, боловсролгүй эрэгтэйчүүдийнх боловсролгүй эмэгтэйчүүдийнхээс 27.8 хувиар байна.

### ХҮСНЭГТ 2.11 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010 ОН.

| | Бүгд | Боловс-ролтой | Үүнээс: түвшингээр | | | | | | Боловс-ролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник мэргэж-лийн | Бүрэн дунд | Суурь | Бага | |
| **УЛСЫН ДҮН** | **56.4** | **56.9** | **75.1** | **61.3** | **66.4** | **51.8** | **49.4** | **46.5** | **46.1** |
| Эрэгтэй | 63.0 | 63.2 | 78.6 | 66.9 | 71.1 | 59.8 | 56.5 | 58.9 | 58.9 |
| Эмэгтэй | 50.1 | 50.9 | 72.6 | 57.7 | 61.1 | 44.0 | 40.3 | 32.5 | 31.1 |
| **ХОТ** | **52.3** | **52.8** | **73.8** | **58.6** | **61.8** | **47.2** | **37.1** | **26.9** | **26.5** |
| Эрэгтэй | 58.5 | 59.0 | 77.8 | 65.5 | 67.4 | 55.8 | 44.9 | 39.4 | 38.4 |
| Эмэгтэй | 46.5 | 47.2 | 70.9 | 54.0 | 55.1 | 38.6 | 27.1 | 15.0 | 14.2 |
| **ХӨДӨӨ** | **66.1** | **67.2** | **84.5** | **70.9** | **73.8** | **71.8** | **63.9** | **58.3** | **55.8** |
| Эрэгтэй | 72.4 | 72.9 | 84.5 | 71.9 | 77.0 | 76.8 | 70.0 | 69.1 | 68.4 |
| Эмэгтэй | 59.3 | 61.1 | 84.5 | 70.3 | 70.3 | 66.9 | 55.9 | 44.6 | 40.3 |

Хот, суурин газарт боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин боловсролгүй хүн амынхаас 26.3 пунктээр их, мөн бага боловсролтой, суурь болон бүрэн дунд боловсролтой хүн амын эдийн засгийн идэвх бага байна. Хэдийгээр бага боловсролтой болон боловсролгүй хүн амын тоо хотод харьцангуй цөөн боловч эдний дотор өндөр настай хүмүүс их, мөн хотод боловсрол багатай хүмүүст ажил эрхлэх боломж бага байдаг юм. Хотын эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо эрэгтэйчүүдийнхээс доогуур байна.

Бага боловсролтой эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин ижил боловсролтой эрэгтэйчүүдийнхээс нэлээд доогуур байгаа нь хот, хөдөөгийн аль алинд адил байна.

Боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцоо улсын дунджаас 0.5 пунктээр илүү, үүний дотор тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүсийнх 4.9 пунктээр, мэргэжлийн болон техникийн боловсролтой хүмүүсийнх 10 пунктээр, дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийнх 18.7 пунктээр их байна. Харин боловсрол эзэмшээгүй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин 10.3 пунктээр, бага боловсролтой хүмүүсийнх 9.9 пунктээр, суурь боловсролтой хүмүүсийнх 7.0 пунктээр, бүрэн дунд боловсролтой хүмүүсийнх 4.6 пунктээр улсын дунджаас доогуур байна.

Ажиллах хүчний оролцооны түвшинг хүн амын насны бүлэг, боловсролын түвшингээр хүснэгт 2.12 болон Зураг 2.4-д харууллаа.

## ХҮСНЭГТ 2.12 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН.

| Насны бүлэг | Бүгд | Боловс-ролтой | Үүнээс: Боловсролын түвшингээр | | | | | | Боловс-ролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Мэргэжлийн болон техникийн | Бүрэн дунд | Суурь | Бага | |
| **БҮГД** | **56.4** | **56.9** | **75.1** | **61.3** | **66.4** | **51.8** | **49.4** | **46.5** | **46.1** |
| 15-19 | 14.4 | 13.1 | 17.9 | 50.4 | 49.8 | 13.6 | 9.0 | 17.0 | 49.9 |
| 20-24 | 55.2 | 54.8 | 73.3 | 73.1 | 72.3 | 38.7 | 70.4 | 78.0 | 65.3 |
| 25-29 | 75.1 | 75.6 | 79.6 | 79.9 | 77.1 | 69.7 | 75.3 | 78.6 | 67.5 |
| 30-34 | 76.9 | 77.5 | 82.3 | 80.5 | 79.0 | 73.4 | 76.4 | 79.6 | 60.5 |
| 35-39 | 77.6 | 78.2 | 85.2 | 80.5 | 79.3 | 75.2 | 76.4 | 75.0 | 50.3 |
| 40-44 | 77.0 | 77.7 | 88.0 | 80.5 | 78.3 | 74.4 | 73.8 | 74.1 | 50.2 |
| 45-49 | 72.2 | 72.9 | 84.8 | 76.2 | 72.4 | 67.8 | 68.5 | 69.5 | 51.5 |
| 50-54 | 58.5 | 59.0 | 75.7 | 58.8 | 57.6 | 51.0 | 54.2 | 57.6 | 45.6 |
| 55-59 | 36.3 | 36.6 | 54.3 | 30.8 | 34.5 | 27.6 | 34.2 | 36.9 | 29.7 |
| 60+ | 8.4 | 8.7 | 16.1 | 7.0 | 8.7 | 5.7 | 7.7 | 7.1 | 5.6 |

15-19 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин бусад насны бүлгийн хүмүүсийнхээс бага байгаа нь энэ насныхан суралцаж байдагтай холбоотой юм. 15-19 насны бүлгийн тусгай мэргэжлийн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүмүүсийн ажиллах хүчний оролцоо 49.8-50.4 хувьтай буюу хамгийн өндөр байна.

Тусгай мэргэжлийн дунд, техникийн болон мэргэжлийн, бүрэн дунд, суурь боловсролтой хүн амын эдийн засгийн идэвх 35-39 насанд, дээд боловсролтой хүн амын эдийн засгийн идэвх 40-44 насанд, бага боловсролтой хүн амын эдийн засгийн идэвх 30-34 насанд, боловсролгүй хүн амын эдийн засгийн идэвх 25-29 насанд өндөр байна.

## ЗУРАГ 2.4 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН.



Дээд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой 20-60 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр байна. 1990-ээд оноос хойш дээд боловсрол олгох шатны байгууллага олноороо байгуулагдаж, суралцагч, төгсөгчдийн тоо нэмэгдсэн нь хөдөлмөрийн зах зээл дэх дээд боловсролтой боловсон хүчний нийлүүлэлтийг ихэсгэхэд, мөн дээд болон тусгай дунд боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн юм.

Бүх насны бүлэгт дээд боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр, боловсролгүй хүн амынх доогуур байна.

Зураг 2.5-аас харахад дээд, суурь, бага боловсролтой эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15 наснаас 24 нас хүртэл эрс өсч, 25-44 насныханд жигд өсөлттэй, 45-59 насныханд аажим буурч, 59-өөс дээш насныханд эрчимтэй буурсан. Боловсролгүй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15-29 хүртэл насныханд жигдхэн өсч, 29-39 хүртэл насныханд жигд буурч, 39-49 хүртэл насныханд аажим өссөн нь боловсрол эзэмшсэн хүмүүсийнхээс өөр дүр зураг харагдаж байна.

Дээд, тусгай мэргэжлийн дунд, техник болон мэргэжлийн, суурь боловсролтой хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин нь зураг 2.5-д үзүүлснээр 20- 24 насны бүлэгт давхцаж байгаа нь онцлог байна. Энэ нь 20-24 насны дээрх боловсролын түвшинтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцоо ойролцоо байгааг харуулж байна.

### ЗУРАГ 2.5 ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН.




Улсын хэмжээнд 15-24 насанд бүх түвшний боловсролтой эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин огцом, 24-34 насанд аажим өсч байгаа боловч 34-өөс дээш насанд жигд бус өсөлттэй байна. 35-49 насны дээд, тусгай мэргэжлийн дунд, техникийн болон мэргэжлийн, бүрэн дунд, суурь боловсролтой эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин жигд өсөлттэй, харин бага боловсролтой болон боловсролгүй эмэгтэйчүүдийнх нилээд хэлбэлзэлтэй байна.

## ЗУРАГ 2.6 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН.




## ХҮСНЭГТ 2.13 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМГААР, 2010 ОН

| Аймаг, нийслэл | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник болон мэргэжлийн | Бүрэн дунд | Суурь | Бага | Боловсролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| **БҮГД** | **75.1** | **61.3** | **66.4** | **51.8** | **49.4** | **46.5** | **46.1** |
| Архангай | 80.4 | 66.2 | 72.7 | 62.8 | 62.4 | 62.7 | 53.5 |
| Баян-Өлгий | 82.2 | 68.7 | 64.7 | 52.5 | 42.0 | 51.3 | 45.2 |
| Баянхонгор | 85.2 | 72.7 | 71.7 | 67.9 | 62.9 | 56.5 | 53.8 |
| Булган | 82.5 | 68.9 | 72.1 | 70.9 | 61.1 | 53.7 | 47.8 |
| Говь-Алтай | 84.4 | 72.4 | 72.7 | 60.8 | 58.4 | 54.9 | 51.9 |
| Дорноговь | 82.6 | 68.2 | 74.3 | 63.2 | 58.9 | 48.5 | 55.6 |
| Дорнод | 79.2 | 58.8 | 61.0 | 57.0 | 43.2 | 36.3 | 40.6 |
| Дундговь | 84.4 | 71.2 | 76.0 | 70.1 | 63.5 | 57.1 | 57.0 |
| Завхан | 83.6 | 70.6 | 70.6 | 61.2 | 51.6 | 48.9 | 45.9 |
| Өвөрхангай | 83.8 | 69.8 | 69.0 | 66.4 | 58.1 | 55.1 | 53.5 |
| Өмнөговь | 87.6 | 76.2 | 79.8 | 81.9 | 71.1 | 57.2 | 56.4 |
| Сүхбаатар | 84.3 | 63.6 | 68.0 | 66.9 | 60.1 | 54.2 | 61.2 |
| Сэлэнгэ | 77.9 | 60.2 | 66.2 | 61.1 | 48.1 | 38.1 | 39.4 |
| Төв | 76.3 | 66.8 | 69.3 | 62.1 | 57.3 | 49.5 | 45.2 |
| Увс | 85.6 | 70.2 | 70.4 | 65.5 | 51.0 | 53.4 | 50.9 |
| Ховд | 82.4 | 68.6 | 69.1 | 55.2 | 48.3 | 45.7 | 45.0 |
| Хөвсгөл | 79.5 | 65.1 | 66.4 | 65.0 | 53.4 | 54.9 | 51.2 |
| Хэнтий | 81.5 | 65.0 | 66.6 | 66.0 | 53.7 | 45.7 | 46.9 |
| Дархан-Уул | 75.6 | 61.2 | 64.1 | 48.8 | 38.6 | 28.6 | 31.4 |
| Улаанбаатар | 72.0 | 56.2 | 61.2 | 44.3 | 37.1 | 23.1 | 21.5 |
| Орхон | 77.2 | 64.1 | 69.2 | 56.7 | 37.5 | 28.8 | 29.5 |
| Говьсүмбэр | 84.8 | 70.5 | 72.7 | 67.6 | 47.1 | 43.3 | 45.5 |

Аймаг, нийслэлийн хувьд мөн л дээд боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр, бага боловсролтой болон боловсролгүй хүн амынх хамгийн доогуур байна. Улаанбаатар хотын хувьд боловсролгүй болон бага боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн бага байна.

## 2.7 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ГЭР БҮЛИЙН БАЙДЛААР

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар 18 нас хүрсэн хүн гэрлэх ёстой боловч амьдралд 18-аас доош насны хүмүүс гэрлэх тохиолдол цөөнгүй байдаг. Олон улсын аргачлалын дагуу 15 наснаас эхлэн гэр бүлийн байдлыг асуусан бөгөөд гэрлэлтийн байдлыг 15 ба түүнээс дээш насаар гаргав.

2010 оны тооллогын дүнгээр батлуулсан гэр бүлтэй хүмүүсийн АХОТ 68.0 хувь байгаа нь бусад төрлийн гэр бүлийнхээс харьцангүй өндөр юм. Батлуулсан гэр бүлтэй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 74.2 хувь, гэр бүлээ цуцалсан эмэгтэйчүүдийнхээс 67.6 хувь буюу хамгийн өндөр байна

Ажиллах хүчний оролцооны түвшин бэлбэсэн хүмүүсийн дунд хамгийн бага (25.6 хувь) байгаа нь ерөнхийдөө эдгээр хүмүүс голдуу өндөр настай, түүнчлэн тэжээж, тэтгэх насанд хүрсэн хүүхдүүдтэй байдагтай, мөн огт гэр бүл болоогүй хүн амынх (39.6 хувь) бага байгаа нь огт гэр бүл болоогүй хүн амын ихэнх нь 25-аас доош насны залуучууд байгаагийн нилээд хувь нь сургуульд суралцаж байгаатай холбоотой юм.

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 1.1-12.4 пунктээр доогуур байна

Сүүлийн 2 тооллогын үр дүнгээс харахад бэлбэсэн хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин 0.3 пунктээр нэмэгдсэн байхад, бусад төрлийн гэр бүлийн ажиллах хүчний оролцооны түвшин буурсан байна. Тухайлбал: 2010 онд батлуулсан гэр бүлтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин 68.0 хувь байгаа нь 2000 оныхоос 3.0 пунктээр буурсан, харин бэлбэсэн хүмүүсийнх 0.3 пунктээр нэмэгджээ.

### ХҮСНЭГТ 2.14. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

| | 2000 | | | 2010 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **61.9** | **68.6** | **55.5** | **56.4** | **63.0** | **50.1** |
| Огт гэр бүл болоогүй | 53.2 | 59.6 | 45.5 | 39.6 | 45.6 | 32.6 |
| Батлуулсан гэр бүлтэй | 71.0 | 76.2 | 65.9 | 68.0 | 74.2 | 61.8 |
| Батлуулаагүй гэр бүлтэй | 68.6 | 75.9 | 61.8 | 64.9 | 73.5 | 56.8 |
| Тусгаарласан | 67.0 | 65.9 | 67.8 | 64.1 | 63.4 | 64.7 |
| Цуцалсан | 67.6 | 65.3 | 69.0 | 65.3 | 62.2 | 67.6 |
| Бэлбэсэн | 25.3 | 29.6 | 24.2 | 25.6 | 26.5 | 25.4 |

## 2.8 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны 1906.0 мянган хүн амьдарч байгаа бөгөөд тэдний 98.6 мянга нь буюу 5.2 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлийн хэлбэртэй гэж тоологджээ. Харин эдийн засгийн идэвхтэй 1075.8 мянган хүн байгаагийн 22.6 мянга буюу 2.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, үүнээс 19.7 мянга буюу 87.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байхад 2.9 мянган хүн ажил хайж байгаа юм. Хөдөө орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн идэвхтэй байдал хот, суурин газрынхаас 16.8 пунктээр илүү байна.

### ХҮСНЭГТ 2.15. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

| | | 15, түүнээс дээш насны хүн ам | Эдийн засгийн идэвхтэй хүн ам | Үүнээс: Хөдөлмөр эрхэлдэг | Үүнээс: Ажилгүй иргэд | АХОТ |
|---|---|---|---|---|---|---|
| **УЛСЫН ХЭМЖЭЭНД** | | | | | | |
| **БҮГД** | | **1 905 969** | **1 075 780** | **911 664** | **164 116** | **56.4** |
| Хөгжлийн бэрхшээлгүй | | 1 807 359 | 1 053 208 | 892 007 | 161 201 | 58.3 |
| Хөгжлийн бэрхшээлтэй | | 98 610 | 22 572 | 19 657 | 2 915 | 22.9 |
| Үүнээс: | Харааны | 14 759 | 4 988 | 4 313 | 675 | 33.8 |
| | Ярианы | 4 774 | 1 192 | 1 031 | 161 | 25.0 |
| | Сонсголын | 11 863 | 3 916 | 3 337 | 579 | 33.0 |
| | Хөдөлгөөний | 28 562 | 6 139 | 5 401 | 738 | 21.5 |
| | Сэтгэцийн | 19 297 | 2 401 | 2 112 | 289 | 12.4 |
| | Бусад | 19 355 | 3 936 | 3 463 | 473 | 20.3 |
| **ХОТ** | | **1 331 679** | **695 900** | **581 329** | **114 571** | **52.3** |
| Хөгжлийн бэрхшээлгүй | | 1 270 069 | 685 673 | 572 911 | 112 762 | 54.0 |
| Хөгжлийн бэрхшээлтэй | | 61 610 | 10 227 | 8 418 | 1 809 | 16.6 |
| Үүнээс: | Харааны | 8 725 | 2 268 | 1 869 | 399 | 26.0 |
| | Ярианы | 2 688 | 447 | 349 | 98 | 16.6 |
| | Сонсголын | 7 500 | 1 855 | 1 481 | 374 | 24.7 |
| | Хөдөлгөөний | 17 994 | 2 955 | 2 501 | 454 | 16.4 |
| | Сэтгэцийн | 11 431 | 765 | 574 | 191 | 6.7 |
| | Бусад | 13 272 | 1 937 | 1 644 | 293 | 14.6 |
| **ХӨДӨӨ** | | **574 290** | **379 880** | **330 335** | **49 545** | **66.1** |
| Хөгжлийн бэрхшээлгүй | | 537 290 | 367 535 | 319 096 | 48 439 | 68.4 |
| Хөгжлийн бэрхшээлтэй | | 37 000 | 12 345 | 11 239 | 1 106 | 33.4 |
| Үүнээс: | Харааны | 6 034 | 2 720 | 2 444 | 276 | 45.1 |
| | Ярианы | 2 086 | 745 | 682 | 63 | 35.7 |
| | Сонсголын | 4 363 | 2 061 | 1 856 | 205 | 47.2 |
| | Хөдөлгөөний | 10 568 | 3 184 | 2 900 | 284 | 30.1 |
| | Сэтгэцийн | 7 866 | 1 636 | 1 538 | 98 | 20.8 |
| | Бусад | 6 083 | 1 999 | 1 819 | 180 | 32.9 |

Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 98.6 мянган хүн байгаагаас 22.6 мянга буюу 22.9 хувь эдийн засгийн идэвхтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их буюу 27.2 хувийг эзэлж байна. Харааны бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин 33.8 хувь байхад сонсголын бэрхшээлтэй хүмүүсийнх 33.0 хувь, ярианы бэрхшээлтэй хүмүүсийнх 25.0 хувь, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийнх 21.5 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийнх 12.4 хувь буюу хамгийн бага байна.

Зураг 2.7-аас харахад хөдөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин хотын иргэдийнхээс 16.8 пунктээр илүү байна. Хөдөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхэлж эсвэл ажил хайж байгаа дүн гарлаа. Хотод харааны болон сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин илүү өндөр байна.

ЗУРАГ 2.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН




## 2.9 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР

Монгол Улсын эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт шинэчлэлт гарч, хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод илүү таатай нөхцөл боломж бүрдсэн, нөгөөтэйгүүр хөдөө, орон нутагт хөдөө аж ахуйн салбарын нөхцөл байдал хүнд хэвээр, нийгэм эдийн засгийн боломж тааруу байгаа зэрэг нь иргэдийг хот, суурин газар руу шилжин нүүхэд хүргэж байна.

Хүн ам, орон сууцны тооллогоор байнга оршин сууж байсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэлийн түвшинд) өөр газар руу 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар шилжин суурьшсан хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзсэн.

Хүснэгт 2.16-т хүн амын эдийн засгийн идэвхийг шилжих хөдөлгөөнд ороогүй, 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон гэсэн 3 үзүүлэлтээр авч үзэв. Монгол Улсад 15, түүнээс дээш насны 1906.0 мянган хүн ам амьдарч байгаагаас 47.6 хувь нь шилжих хөдөлгөөнд ороогүй, 47.4 хувь нь 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 5.0 хувь нь 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон байв. Шилжих хөдөлгөөнд ороогүй 906.6 мянган хүний ажиллах хүчний оролцооны түвшин 55.0 хувь,

2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон 904.1 мянган хүнийх 58.3 хувь, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон 95.3 мянган хүнийх 53.0 хувь байгаагаас харахад 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийнхээс 3.3 пунктээр, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийнхээс 5.3 пунктээр илүү байна.

2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон эдийн засгийн идэвхтэй хүн амын 87.2 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь шилжих хөдөлгөөнд ороогүй (82.5 хувь) болон 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон эдийн засгийн идэвхтэй хүн амын дотор хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хувиас өндөр байна.

2010 онд шилжилт хийсэн эдийн засгийн идэвхтэй хүн амын 19.2 хувь, шилжих хөдөлгөөнд ороогүй эдийн засгийн идэвхтэй хүн амын 17.5 хувь, 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон эдийн засгийн идэвхтэй хүн амын 12.8 хувь нь ажил хайж байна.

## ХҮСНЭГТ 2.16. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН

| Шилжих хөдөлгөөний байдал | | 15, түүнээс дээш насны хүн ам | Эдийн засгийн идэвхтэй хүн ам | Хөдөлмөр эрхэлдэг | Ажил хайж байгаа | АХОТ |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | **БҮГД** | **1 905 969** | **1 075 780** | **911 664** | **164 116** | **56.4** |
| | Эрэгтэй | 937 271 | 590 132 | 495 101 | 95 031 | 63.0 |
| | Эмэгтэй | 968 698 | 485 648 | 416 563 | 69 085 | 50.1 |
| Шилжих хөдөлгөөнд ороогүй | **БҮГД** | **906 609** | **498 505** | **411 509** | **86 996** | **55.0** |
| | Эрэгтэй | 422 207 | 256 364 | 208 409 | 47 955 | 60.7 |
| | Эмэгтэй | 484 402 | 242 141 | 203 100 | 39 041 | 50.0 |
| 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон | **БҮГД** | **904 071** | **526 768** | **459 334** | **67 434** | **58.3** |
| | Эрэгтэй | 463 641 | 300 514 | 258 970 | 41 544 | 64.8 |
| | Эмэгтэй | 440 430 | 226 254 | 200 364 | 25 890 | 51.4 |
| 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон | **БҮГД** | **95 289** | **50 507** | **40 821** | **9 686** | **53.0** |
| | Эрэгтэй | 51 423 | 33 254 | 27 722 | 5 532 | 64.7 |
| | Эмэгтэй | 43 866 | 17 253 | 13 099 | 4 154 | 39.3 |

Хотод шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин 50.7 хувь байхад 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийнх 54.4 хувь, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийнх 43.3 хувь байв. Хөдөөд сүүлийн 1 жилд шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин шилжих хөдөлгөөнд ороогүй болон 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийнхээс 8.7-20.7 пунктээр илүү байна.

## ХҮСНЭГТ 2.17. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН

| | Бүгд | | | Шилжих хөдөлөөнд ороогүй | | | 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон | | | 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **56.4** | **63.0** | **50.1** | **55.0** | **60.7** | **50.0** | **58.3** | **64.8** | **51.4** | **53.0** | **64.7** | **39.3** |
| Хот | 52.3 | 58.5 | 46.5 | 50.7 | 56.4 | 45.5 | 54.4 | 60.6 | 48.6 | 43.3 | 53.2 | 33.9 |
| Хөдөө | 66.1 | 72.4 | 59.3 | 61.4 | 67.5 | 56.4 | 73.4 | 76.9 | 67.1 | 82.1 | 88.8 | 66.7 |

Сүүлийн 1 жилд шилжих хөдөлгөөнд орсон хөдөөгийн эрэгтэйчүүдийн 76.9 хувь эдийн засгийн идэвхтэй гэж тоологджээ. Шилжих хөдөлгөөнд орсон болон ороогүй эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхтэй байдал хот, хөдөөд онцын ялгаа харагдахгүй байна.

## ЗУРАГ 2.8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, СҮҮЛИЙН 1 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН




Шилжилт хөдөлгөөнд ороогүй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 60.7 хувь байхад 2010 онд шилжилт хөдөлгөөнд орсон эмэгтэйчүүдийнх 39.3 хувь буюу хамгийн бага байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөнийг судалсан юм. 2000 оны тооллогын хувьд сүүлийн 5 жил гэдэгт 1995-2000 оныг, 2010 оны тооллогын хувьд сүүлийн 5 жил гэдэгт 2005-2010 оныг хамруулав.

Зураг 2.9-д сүүлийн 2 удаагийн тооллогод хамрагдсан хүн амын ажиллах хүчний оролцооны түвшинг тооллогын өмнөх 5 жилд шилжих хөдөлгөөнд орсон болон шилжих хөдөлгөөнд ороогүй гэсэн ангиллаар харууллаа. Энд 2005-2010 онд шилжих хөдөлгөөнд орсон хүн амын 52.4 хувь нь тодорхой хөдөлмөр эрхэлж байгаа болон ажилгүй иргэд байна. Эдгээр хүмүүсээс эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 61.5 хувь, эмэгтэйчүүдийнх 43.1 хувьтай байна.

## ЗУРАГ 2.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙСЭЭР, СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2000, 2010 ОН



1990 оноос хойш ажил, хөдөлмөр эрхлэх, сургуульд суралцах гэх мэт олон шалтгааны улмаас хот, суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж байсан бол төр, засгаас хүн амын хөгжлийн бодлого, хөтөлбөр, бүс нутгийн хөгжлийг дэмжсэн олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр сүүлийн 5 жилд шилжилт хөдөлгөөн буурсан гэж дүгнэж болох юм.

Хүснэгт 2.18-т сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд орсон болон ороогүй хүн амын эдийн засгийн идэвхийг аймгаар үзүүллээ. Дундговь аймгийн хувьд сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд ороогүй нийт хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 78.8 хувьтай байхад Дорнод аймгийн хувьд энэ үзүүлэлт 52.9 хувь буюу хамгийн бага байна. Харин Өмнөговь аймгийн хувьд 2000 оноос хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 63.6 хувьтай байхад Орхон аймагт 43.6 хувь буюу хамгийн бага байна. Түүнчлэн Өмнөговь аймагт сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр буюу 92.2 хувь, Улаанбаатар хотод 42.4 хувь буюу хамгийн бага байна.

## ХҮСНЭГТ 2.18. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН

| | Бүгд | | | Шилжих хөдөлгөөнд ороогүй | | | Сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд ороогүй | | | Сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд орсон | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **УЛСЫН ДҮН** | **56.4** | **63.0** | **50.1** | **55.0** | **60.7** | **50.0** | **59.9** | **66.1** | **53.2** | **52.4** | **61.5** | **43.1** |
| Архангай | 63.9 | 69.5 | 58.4 | 61.0 | 65.6 | 57.5 | 75.7 | 77.0 | 72.5 | 53.2 | 68.7 | 43.3 |
| Баян-өлгий | 54.2 | 62.5 | 46.0 | 49.1 | 58.5 | 41.0 | 68.6 | 70.0 | 66.1 | 76.3 | 82.5 | 70.6 |
| Баянхонгор | 65.2 | 69.5 | 60.8 | 58.7 | 61.8 | 56.6 | 77.4 | 77.7 | 76.6 | 77.4 | 77.4 | 77.4 |
| Булган | 65.3 | 69.7 | 60.7 | 59.5 | 64.1 | 55.6 | 71.4 | 74.4 | 67.0 | 73.4 | 76.1 | 70.4 |
| Говь-Алтай | 62.4 | 68.7 | 56.1 | 56.9 | 62.0 | 53.3 | 74.8 | 75.6 | 72.9 | 62.4 | 76.8 | 48.9 |
| Дорноговь | 63.9 | 71.3 | 56.4 | 57.9 | 63.8 | 53.1 | 70.2 | 74.9 | 63.7 | 68.4 | 80.9 | 54.5 |
| Дорнод | 53.3 | 59.5 | 47.0 | 52.5 | 58.7 | 46.6 | 52.9 | 57.9 | 47.3 | 64.6 | 73.5 | 52.7 |
| Дундговь | 65.8 | 69.8 | 61.7 | 58.6 | 60.6 | 57.3 | 78.8 | 79.6 | 76.6 | 80.7 | 81.3 | 80.1 |
| Завхан | 58.8 | 64.3 | 53.4 | 53.2 | 58.0 | 49.6 | 74.1 | 74.7 | 72.6 | 65.0 | 69.0 | 61.2 |
| Өвөрхангай | 62.1 | 67.9 | 56.3 | 57.5 | 64.0 | 52.5 | 72.3 | 73.7 | 69.5 | 73.7 | 76.1 | 71.2 |
| Өмнөговь | 74.7 | 81.9 | 64.1 | 63.6 | 69.9 | 58.2 | 75.3 | 76.9 | 72.7 | 92.2 | 95.9 | 77.9 |
| Сүхбаатар | 63.6 | 69.6 | 57.4 | 57.2 | 64.1 | 51.8 | 72.6 | 74.5 | 69.2 | 78.5 | 82.4 | 74.1 |
| Сэлэнгэ | 57.7 | 63.5 | 51.6 | 51.5 | 58.3 | 43.7 | 58.9 | 64.0 | 54.1 | 69.5 | 75.3 | 63.1 |
| Төв | 60.3 | 66.0 | 54.0 | 55.3 | 61.5 | 48.8 | 64.2 | 69.3 | 58.3 | 65.7 | 70.6 | 60.0 |
| Увс | 60.4 | 66.1 | 54.7 | 50.6 | 54.9 | 47.8 | 75.2 | 76.2 | 73.0 | 78.2 | 78.9 | 77.3 |
| Ховд | 55.9 | 62.8 | 49.1 | 51.9 | 58.7 | 46.3 | 69.6 | 71.6 | 66.0 | 53.1 | 65.1 | 42.5 |
| Хөвсгөл | 60.1 | 65.8 | 54.6 | 57.7 | 64.2 | 52.1 | 68.4 | 69.9 | 65.9 | 69.2 | 71.6 | 67.1 |
| Хэнтий | 59.6 | 64.8 | 54.3 | 51.5 | 55.3 | 48.8 | 67.8 | 70.9 | 62.5 | 70.3 | 76.0 | 63.9 |
| Дархан-Уул | 52.5 | 59.0 | 46.4 | 53.6 | 59.3 | 47.4 | 55.8 | 61.7 | 50.5 | 42.9 | 51.7 | 34.8 |
| Улаанбаатар | 51.9 | 58.6 | 45.8 | 54.2 | 60.1 | 48.7 | 54.0 | 60.8 | 48.2 | 42.4 | 51.0 | 34.5 |
| Орхон | 56.5 | 62.8 | 50.6 | 43.6 | 49.3 | 37.2 | 59.6 | 65.5 | 54.3 | 55.2 | 64.5 | 46.5 |
| Говьсүмбэр | 62.7 | 67.3 | 57.8 | 55.4 | 61.4 | 48.9 | 64.6 | 69.7 | 59.6 | 64.8 | 67.7 | 61.3 |

## 2.10 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ

Тооллогын товын өмнөх сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, ажил хайгаагүй, харин гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэрт, сургуульд суралцдаг болон бусад шалтгааны улмаас идэвхгүй байсан нийт хүн амыг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажиллах хүчнээс гадуурх хүн амд оруулдаг. Иймд сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг ажил хийгээгүй /эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй/, ажлын байргүй, ажил хийхэд бэлэн бус байсан хүмүүсийг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амд тооцсон.

2010 оны байдлаар Монгол Улсын 15, түүнээс дээш насны 1906.0 мянган хүмүүсийн 43.6 хувийг эдийн засгийн идэвхгүй хүн ам эзэлж, харин 2000 онд энэ үзүүлэлт 38.1 хувь байжээ. Өөрөөр хэлбэл нийт хүн амд эдийн засгийн идэвхгүй хүн амын эзлэх хувь 5.5 пунктээр өсчээ.

### ХҮСНЭГТ 2.19. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ, ШАЛТГААНААР, 2000, 2010 ОН

| | 2000 | | 2010 | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дунд эзлэх хувь | Тоо | Дунд эзлэх хувь | |
| **15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ** | **1 524 372** | **38. 1** | **1 905 969** | **43.6** | **125.0** |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 580 289 | 100.0 | 830 189 | 100.0 | 143.1 |
| Сургуульд сурдаг | 171 003 | 29. 5 | 300 494 | 36.2 | 175.7 |
| Тэтгэвэрт | 163 666 | 28. 2 | 191 907 | 23.1 | 117.3 |
| Хөдөлмөр эрхлэх чадваргүй | 36 912 | 6. 4 | 55 888 | 6.7 | 151.4 |
| Гэрийн ажилтай | 76 307 | 13. 1 | 108 403 | 13.1 | 142.1 |
| Тохирох ажил олдохгүй байгаа | 90 353 | 15. 6 | 121 519 | 14.6 | 134.5 |
| Ажил хийхийг хүсээгүй | - | - | 3 283 | 0.4 | - |
| Бусад | 42 048 | 7. 2 | 48 695 | 5.9 | 115.8 |

Улсын хэмжээнд 2000 оны байдлаар 580.3 мянган эдийн засгийн идэвхгүй хүн байсан бол 2010 онд 830.2 мянга болж 43.1 хувиар өслөө. Эдийн засгийн идэвхгүй хүн амын өсөлтийг шалтгаанаар судалж үзэхэд сургуульд сурдаг хүн амын тоо 75.7 хувиар, хөдөлмөр эрхлэх чадваргүй хүн ам 51.4 хувиар, гэрийн ажилтай хүн ам 42.1 хувиар, тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулсан хүн амын тоо 34.5 хувь, өндөр настай буюу тэтгэвэрт байдаг гэж хариулсан хүн амын тоо 17.3 хувь, бусад шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй байгаа хүн амын тоо 15.8 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 2.20-д эдийн засгийн идэвхгүй хүн амыг насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр үзүүлэв. Улсын хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн амын 58.2 хувь нь эмэгтэйчүүд, 41.8 хувь нь эрэгтэйчүүд, 76.6 хувь хотод, 23.4 хувь нь хөдөөд оршин сууж байна. Эдийн засгийн идэвхгүй хотын эмэгтэйчүүдийн эзлэх хувь хөдөөгийн эмэгтэйчүүдийнхээс 1 пунктээр их байхад харин эдийн засгийн идэвхгүй хотын эрэгтэйчүүдийн эзлэх хувь хөдөөгийн эрэгтэйчүүдийнхээс 1.0 пунктээр бага байна.

Насны бүлгээр авч үзэхэд хот, хөдөөд эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо ялгаатай байна. Улсын хэмжээнд 15-24 насны бүлэгт хамаарах эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өндөр байгаа нь энэ насны хүн амын ихэнх нь сургуульд суралцаж байгаатай холбоотой юм. Хотод 15-24 насны эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өндөр, харин хөдөөд 15-19, 65 ба түүнээс дээш насны бүлэгт эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өндөр байна. Хот, хөдөөд 40-44 насны бүлэгт хамаарах эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо хамгийн бага байна.

## ХҮСНЭГТ 2.20. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

| Насны бүлэг | Улсын дүн | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **830189** | **347139** | **483050** | **635779** | **264297** | **371482** | **194410** | **82842** | **111568** |
| 15-19 | 220522 | 104683 | 115839 | 170323 | 80319 | 90004 | 50199 | 24364 | 25835 |
| 20-24 | 130919 | 53110 | 77809 | 114555 | 46122 | 68433 | 16364 | 6988 | 9376 |
| 25-29 | 61752 | 21397 | 40355 | 47709 | 15571 | 32138 | 14043 | 5826 | 8217 |
| 30-34 | 51441 | 19385 | 32056 | 38272 | 13839 | 24433 | 13169 | 5546 | 7623 |
| 35-39 | 45325 | 18862 | 26463 | 33708 | 13786 | 19922 | 11617 | 5076 | 6541 |
| 40-44 | 41170 | 18521 | 22649 | 30425 | 13740 | 16685 | 10745 | 4781 | 5964 |
| 45-49 | 44071 | 19768 | 24303 | 33210 | 14926 | 18284 | 10861 | 4842 | 6019 |
| 50-54 | 50612 | 19644 | 30968 | 37338 | 14955 | 22383 | 13274 | 4689 | 8585 |
| 55-59 | 45840 | 15459 | 30381 | 33567 | 11819 | 21748 | 12273 | 3640 | 8633 |
| 60-64 | 42081 | 17216 | 24865 | 30598 | 12489 | 18109 | 11483 | 4727 | 6756 |
| 65+ | 96456 | 39094 | 57362 | 66074 | 26731 | 39343 | 30382 | 12363 | 18019 |

Хүснэгт 2.21-д эдийн засгийн идэвхгүй хүн амыг боловсролын түвшингээр задлан харууллаа. Энд эдийн засгийн идэвхгүй нийт 830.2 мян.хүн байгаагийн 94.7 хувь буюу 786.1 мян.хүн боловсролтой, 5.3 хувь буюу 44.1 мянган хүн боловсролгүй байна. Боловсрол эзэмшсэн эдийн засгийн идэвхгүй хүн амыг боловсролын түвшингээр авч үзвэл бүрэн дунд боловсролтой хүн ам 42.0 хувь буюу хамгийн өндөр, суурь боловсролтой хүн ам 23.6 хувь, бага боловсролтой хүн ам 13.3 хувь, дээд боловсролтой хүн ам 12.4 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ам 6.0 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн ам 2.6 хувийг эзэлж байна.

## ХҮСНЭГТ 2.21. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН.

| Эдийн засгийн идэвхийн байдал | Бүгд | Боловс-ролтой | Үүнээс: Боловсролын түвшингээр | | | | | | Боловс-ролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник болон мэргэжлийн | Бүрэн дунд | Суурь | Бага | |
| **БҮГД** | | | | | | | | | |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 830 189 | 786 135 | 97 865 | 47 551 | 20 243 | 330 281 | 185 451 | 104 744 | 44 054 |
| Сургуульд сурдаг | 300 494 | 299 481 | 14 451 | 2 334 | 2 526 | 160 006 | 94 929 | 25 235 | 1 013 |
| Тэтгэвэрт | 191 907 | 173 733 | 29 281 | 25 107 | 5 431 | 37 833 | 25 292 | 50 789 | 18 174 |
| Хөдөлмөр эрхлэх чадваргүй | 55 888 | 42 496 | 3 748 | 3 671 | 2 102 | 15 924 | 10 505 | 6 546 | 13 392 |
| Гэрийн ажилтай | 108 403 | 104 766 | 22 960 | 6 083 | 3 185 | 47 381 | 17 529 | 7 628 | 3 637 |
| Тохирох ажил олдохгүй байгаа | 121 519 | 116 872 | 15 937 | 7 437 | 5 463 | 50 042 | 27 598 | 10 395 | 4 647 |
| Ажиллах сонирхолгүй | 3 283 | 3 003 | 442 | 149 | 107 | 1 214 | 761 | 330 | 280 |
| Бусад | 48 695 | 45 784 | 11 046 | 2 770 | 1 429 | 17 881 | 8 837 | 3 821 | 2 911 |
| **ЭРЭГТЭЙ** | | | | | | | | | |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 347 139 | 329 107 | 34 703 | 15 989 | 9 331 | 136 606 | 89 662 | 42 816 | 18 032 |
| Сургуульд сурдаг | 71 856 | 68 696 | 7 061 | 3 608 | 3 157 | 29 200 | 18 451 | 7 219 | 3 160 |
| Тэтгэвэрт | 136 696 | 136 177 | 5 183 | 1 080 | 1 438 | 69 574 | 46 113 | 12 789 | 519 |
| Хөдөлмөр эрхлэх чадваргүй | 65 745 | 61 230 | 15 204 | 7 414 | 2 145 | 12 995 | 8 885 | 14 587 | 4 515 |
| Гэрийн ажилтай | 31 256 | 24 234 | 1 976 | 1 815 | 1 236 | 8 816 | 6 529 | 3 862 | 7 022 |
| Тохирох ажил олдохгүй байгаа | 12 122 | 11 593 | 1 245 | 692 | 435 | 5 315 | 2 663 | 1 243 | 529 |
| Ажиллах сонирхолгүй | 2 321 | 2 116 | 271 | 88 | 78 | 841 | 589 | 249 | 205 |
| Бусад | 27 143 | 25 061 | 3 763 | 1 292 | 842 | 9 865 | 6 432 | 2 867 | 2 082 |
| **ЭМЭГТЭЙ** | | | | | | | | | |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 483 050 | 457 028 | 63 162 | 31 562 | 10 912 | 193 675 | 95 789 | 61 928 | 26 022 |
| Сургуульд сурдаг | 163 798 | 163 304 | 9 268 | 1 254 | 1 088 | 90 432 | 48 816 | 12 446 | 494 |
| Тэтгэвэрт | 126 162 | 112 503 | 14 077 | 17 693 | 3 286 | 24 838 | 16 407 | 36 202 | 13 659 |
| Хөдөлмөр эрхлэх чадваргүй | 24 632 | 18 262 | 1 772 | 1 856 | 866 | 7 108 | 3 976 | 2 684 | 6 370 |
| Гэрийн ажилтай | 96 281 | 93 173 | 21 715 | 5 391 | 2 750 | 42 066 | 14 866 | 6 385 | 3 108 |
| Тохирох ажил олдохгүй байгаа | 49 663 | 48 176 | 8 876 | 3 829 | 2 306 | 20 842 | 9 147 | 3 176 | 1 487 |
| Ажиллах сонирхолгүй | 962 | 887 | 171 | 61 | 29 | 373 | 172 | 81 | 75 |
| Бусад | 21 552 | 20 723 | 7 283 | 1 478 | 587 | 8 016 | 2 405 | 954 | 829 |

Нийт эрэгтэйчүүдийн 39.4 хувь, эмэгтэйчүүдийн 33.9 хувь нь сургуульд суралцаж байгаа гэж хариулсан нь эдийн засгийн идэвхгүй байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Эрэгтэйчүүдийн 18.9 хувь, эмэгтэйчүүдийн 26.1 хувь өндөр настай буюу тэтгэвэрт гарсан, 3.5 хувь болон 19.9 хувь гэрийн ажилтай байна. Ийнхүү эдийн засгийн идэвхгүй байгаагийн үндсэн шалтгаанд сургуульд сурдаг, өндөр настай буюу тэтгэвэрт байгаа гэсэн хоёр шалтгаан орж байна.

ЗУРАГ 2.10. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН БҮТЭЦ, ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН.




Эдийн засгийн идэвхгүй хүн амыг аймгаар хавсралт 1-ийн хүснэгт 1-д үзүүлсэн бөгөөд 2000 онтой харьцуулахад Өмнөговь аймагт хамгийн их буюу 76.7 хувиар нэмэгдсэн байв.

Мөн эдийн засгийн идэвхгүй хүн ам Улаанбаатар хотод 63.8 хувиар, Орхон аймагт 61.6 хувиар Дорноговь аймагт 59.7 хувиар, Өвөрхангай аймагт 52.9 хувиар, бусад аймгуудад 1.7- 45.3 хувиар нэмэгджээ.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



## 3.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Тооллогоор "Хөдөлмөр эрхэлж буй хүн ам" буюу "Ажил эрхэлдэг хүн ам"-д ямар шалгуур хангасан хүмүүсийг хамруулсан талаар судалгааны эхний бүлэгт тодорхой дурдсан билээ. Хөдөлмөр эрхэлдэг бүх хүнээс тэдний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн байдал гэсэн гурван асуултыг асуусан. Хүснэгт 3.1-д хөдөлмөр эрхэлж байгаа хүн ам буюу ажиллагчдыг хот хөдөө, хүйсээр 2000, 2010 оны тооллогын дүнгээр харуулав. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо 2000 оноос хойш 17.0 хувиар өсчээ. Хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд илүү өсөлттэй байна. Хүснэгтээс харахад хөдөлмөр эрхэлж байгаа 911.7 мянган хүн байгаагийн 54.3 хувь буюу 495.1 мянга нь эрэгтэйчүүд, 45.7 хувь буюу 416.6 мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны хүн амын 47.8 хувь нь хөдөлмөр эрхэлдэг бөгөөд уг үзүүлэлт хөдөөд 57.5 хувь байгаа нь хотынхоос 13.8 пунктээр илүү байна. Хөдөөгийн хүн ам нийт суурин хүн амын 32.1 хувийг эзэлж, хувийн жин нь жилээс жилд буурч байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хотынхоос 12.3 пунктээр их бол эрэгтэйчүүдийнх 14.6 пунктээр илүү байна. Хэдийгээр энэ зөрүү 2000 оны тооллогын үеийнхээс буурсан ч хөдөлмөр эрхлэх зорилгоор хот суурин руу нүүж, амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн олон мянган хүн ажлын байраар тэр бүр хангагдаж чадахгүй байсаар байна.

ХҮСНЭГТ 3.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ ХҮЙСЭЭР 2000, 2010 ОН

| Хүйс | 2000 он | 2010 он | $\frac{2010}{2000}$ % |
|---|---|---|---|
| | мян.хүн | мян.хүн | |
| **БҮГД** | **779.1** | **911.7** | **117.0** |
| Эрэгтэй | 420.4 | 495.1 | 117.8 |
| Эмэгтэй | 358.7 | 416.6 | 116.1 |
| Хот | 366.0 | 581.3 | 158.8 |
| Хөдөө | 413.1 | 330.4 | 80.0 |

## 3.2 АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БҮС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР

Ажил эрхэлдэг хүн ам байршлаар нэлээд ялгаатай байгааг Хүснэгт 3.2-оос харж болно. Ажил эрхэлдэг хүн амын 63.8 хувь нь хот, суурин газарт байгаагийн зэрэгцээ ажил эрхэлсэн хүний тоо бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Ажил эрхэлдэг хүн амын 42.9 хувь буюу 391.5 мянга нь Улаанбаатар хотод, 20.2 хувь буюу 184.3 мянга нь Хангайн бүсэд, 17.9 хувь буюу 162.9 мянга нь Төвийн бүсэд, 12.2 хувь буюу 110.8 мянга нь Баруун бүсэд, Зүүн бүсэд хамгийн бага өөрөөр хэлбэл 6.8 хувь буюу 62.2 мянга нь байна. Ажил эрхэлдэг хүн амын тоог өмнөх тооллого буюу 2000 оны тооллогын үр дүнтэй харьцуулбал Улаанбаатар хотод хөдөлмөр эрхэлж буй хүний тоо 78.4 хувь, Төвийн бүсэд 9.3 хувь, Зүүн бүсэд 0.2 хувиар өсч, харин Баруун бүсэд 24.2 хувь, Хангайн бүсэд 9.0 хувиар тус тус буурчээ.

## ХҮСНЭГТ 3.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, БҮС НУТАГ, ХҮЙСЭЭР 2000, 2010 ОНООР

| Байршил/ бүс нутаг | 2000 | | | 2010 | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **779151** | **420426** | **358725** | **911664** | **495101** | **416563** | **117.0** |
| Хот | 366044 | 193000 | 173044 | 581329 | 306728 | 274601 | 158.8 |
| Хөдөө | 413107 | 227426 | 185681 | 330335 | 188373 | 141962 | 80.0 |
| | | | | | | | |
| Төв | 149057 | 83114 | 65943 | 162869 | 93382 | 69487 | 109.3 |
| Зүүн | 62040 | 34942 | 27098 | 62195 | 34508 | 27687 | 100.2 |
| Баруун | 146095 | 80627 | 65468 | 110803 | 61104 | 49699 | 75.8 |
| Хангай | 202505 | 108417 | 94088 | 184274 | 98586 | 85688 | 91.0 |
| Улаанбаатар | 219454 | 113326 | 106128 | 391523 | 207521 | 184002 | 178.4 |

Ажил эрхэлж буй 15-24 насны хүний тоо 2000 оныхоос буурч, харин 35-54 насны хүний тоо өссөн нь аж ахуйн нэгж, байгууллага ажлын чадвар, дадлага туршлагатай, ажлын бүтээмж өндөртэй ажилтныг ажиллуулах сонирхол нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр өнгөрсөн жилүүдэд ажиллаж байсан 15-24 насныхан нас дэвшсэнтэй холбоотой. Нөгөө талаар залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс нэмэгдсэн нь энэхүү бууралтанд нөлөөлжээ./Хүснэгт 3.3/

## ХҮСНЭГТ 3.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

*мян.хүн*

| Насны бүлэг | 2000 | | | 2010 | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **779.1** | **420.4** | **358.7** | **911.7** | **495.1** | **416.6** | **117.0** |
| 15-19 | 80.9 | 48.4 | 32.5 | 25.6 | 18.7 | 6.9 | 31.7 |
| 20-24 | 126.0 | 69.0 | 57.0 | 122.9 | 72.7 | 50.2 | 97.5 |
| 25-34 | 252.3 | 131.0 | 121.3 | 300.6 | 163.8 | 136.7 | 119.1 |
| 35-44 | 199.6 | 99.8 | 99.8 | 255.9 | 129.1 | 126.8 | 128.1 |
| 45-54 | 82.8 | 46.5 | 36.3 | 169.1 | 85.4 | 83.7 | 204.3 |
| 55-59 | 22.3 | 16.0 | 6.3 | 25.0 | 16.9 | 8.1 | 112.0 |
| 60+ | 15.2 | 9.7 | 5.5 | 12.6 | 8.5 | 4.2 | 82.6 |

Зураг 3.1-д ажил эрхэлдэг хүн амын тоог 2000, 2010 оны тооллогын дүнгээр хүйсээр харууллаа.

ЗУРАГ 3.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН




Ажил эрхэлж буй хүн амын тоо хүн ам, орон сууцны 2000 оны тооллогынхоос улсын дүнгээр 17.0 хувиар өсөхөд нийслэл Улаанбаатар хот болон Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод аймгуудад 11.2-78.4 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

## 3.3 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

Зураг 3.2-т ажил эрхэлдэг хүн амын тоог эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн голлох 3 салбараар харууллаа. 2000 оныхоос хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлдэг хүн амын тоо 126.6 мянгаар буюу 34.4 хувиар буурсан бол харин үйлдвэрлэлийн салбарт ажил эрхэлдэг хүн ам 86.5 мянгаар буюу 82.3 хувь, үйлчилгээний салбарт ажил эрхэлдэг хүн ам 172.7 мянгаар буюу 56.3 хувиар өсчээ.

ЗУРАГ 3.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН САЛБАРУУДААР, 2000, 2010 ОН



Үйл ажиллагааны голлох салбаруудад гарсан ажил эрхэлдэг хүн амын өөрчлөлт нь 2000 оны тооллогоос хойш малчин өрхүүд зуд, байгалийн гамшигт үзэгдлээс малгүй болж Улаанбаатар хотод шилжин суурьшиж үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарт ажиллаж байгаатай холбоотой байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллыг хуулийн этгээд, өөрөөр хэлбэл, өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амд үйлчилдэг ашгийн бус төр, олон нийт, шашны зэрэг байгууллагууд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь ялгаж, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо болон судалгаа шинжилгээнд ашигладаг. Хүн амын 26.4 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр түвшинд хэвээр байна. /Хүснэгт 3.4/

Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, цахилгаан хий, уур агааржуулалтын хангамж, барилга, тээвэр агуулахын аж ахуй, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажил эрхэлдэг хүн амын 70.0, түүнээс илүү хувь нь эрэгтэйчүүд байхад байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажил эрхэлдэг хүн амын 70.0-аас дээш хувь нь эмэгтэйчүүд байна./Хүснэгт 3.4/

## ХҮСНЭГТ 3.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүн | хувь | хүн | хувь | хүн | хувь |
| **БҮГД** | **911 664** | **100.0** | **495 101** | **54.3** | **416 563** | **45.7** |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 241 017 | 26.4 | 139 428 | 57.8 | 101 589 | 42.2 |
| Уул уурхай, олборлолт | 48 897 | 5.4 | 39 223 | 80.2 | 9 674 | 19.8 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 63 391 | 7.0 | 33 586 | 53.0 | 29 805 | 47.0 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж | 14 257 | 1.6 | 10 770 | 75.5 | 3 487 | 24.5 |
| Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 6 451 | 0.7 | 3 794 | 58.8 | 2 657 | 41.2 |
| Барилга | 58 517 | 6.4 | 46 704 | 79.8 | 11 813 | 20.2 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 117 040 | 12.8 | 51 077 | 43.6 | 65 963 | 56.4 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 52 681 | 5.8 | 42 059 | 79.8 | 10 622 | 20.2 |
| Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 28 446 | 3.1 | 6 315 | 22.2 | 22 131 | 77.8 |
| Мэдээлэл, холбоо | 13 646 | 1.5 | 7 206 | 52.8 | 6 440 | 47.2 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 15 841 | 1.7 | 6 083 | 38.4 | 9 758 | 61.6 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 7 689 | 0.8 | 3 390 | 44.1 | 4 299 | 55.9 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 10 498 | 1.2 | 5 142 | 49.0 | 5 356 | 51.0 |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 12 276 | 1.3 | 8 779 | 71.5 | 3 497 | 28.5 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 74 581 | 8.2 | 49 269 | 66.1 | 25 312 | 33.9 |
| Боловсрол | 79 552 | 8.7 | 21 318 | 26.8 | 58 234 | 73.2 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 35 710 | 3.9 | 6 981 | 19.5 | 28 729 | 80.5 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 8 463 | 0.9 | 4 628 | 54.7 | 3 835 | 45.3 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 19 285 | 2.1 | 8 092 | 42 | 11 193 | 58 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 683 | 0.1 | 182 | 26.6 | 501 | 73.4 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 2 743 | 0.3 | 1 075 | 39.2 | 1 668 | 60.8 |

Ажил эрхэлдэг хотын хүн амын дотор бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, төрийн удирдлага, батлан хамгаалах, боловсролын салбарт ажил эрхэлдэг хүн амын хувийн жин өндөр байна. Гэхдээ салбар салбарын ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь хөдөөгийнх шиг нэг салбарт хэт төвлөрсөн бус харьцангуй жигд тархсан байна.

## ХҮСНЭГТ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

| Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл | Хот | Хөдөө | Ажил эрхэлдэг бүх хүн ам | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хүний тоо-бүгд | Бүгдэд эзлэх хувь | |
| | | | | хот | хөдөө |
| **БҮГД** | **581 329** | **330 335** | **911 664** | **63.8** | **36.2** |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 23 492 | 217 525 | 241 017 | 9.7 | 90.3 |
| Уул уурхай, олборлолт | 32 916 | 15 981 | 48 897 | 67.3 | 32.7 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 57 704 | 5 687 | 63 391 | 91.0 | 9.0 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж | 12 220 | 2 037 | 14 257 | 85.7 | 14.3 |
| Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 5 875 | 576 | 6 451 | 91.1 | 8.9 |
| Барилга | 51 217 | 7 300 | 58 517 | 87.5 | 12.5 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 106 898 | 10 142 | 117 040 | 91.3 | 8.7 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 45 930 | 6 751 | 52 681 | 87.2 | 12.8 |
| Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 25 831 | 2 615 | 28 446 | 90.8 | 9.2 |
| Мэдээлэл, холбоо | 12 976 | 670 | 13 646 | 95.1 | 4.9 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 13 317 | 2 524 | 15 841 | 84.1 | 15.9 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 7 644 | 45 | 7 689 | 99.4 | 0.6 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 8 664 | 1 834 | 10 498 | 82.5 | 17.5 |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 10 587 | 1 689 | 12 276 | 86.2 | 13.8 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 54 132 | 20 449 | 74 581 | 72.6 | 27.4 |
| Боловсрол | 56 263 | 23 289 | 79 552 | 70.7 | 29.3 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 27 301 | 8 409 | 35 710 | 76.5 | 23.5 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 7 377 | 1 086 | 8 463 | 87.2 | 12.8 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 17 876 | 1 409 | 19 285 | 92.7 | 7.3 |
| Хүн хөлсөлж ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 634 | 49 | 683 | 92.8 | 7.2 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 2 475 | 268 | 2 743 | 90.2 | 9.8 |

Хөдөө аж ахуй, ан агнуур, загас барилт, ойн аж ахуйн салбарт ажил эрхэлдэг хүн ам хөдөөгийн ажил эрхэлдэг хүн амын 2/3-ыг бүрдүүлж, дараа нь төрийн удирдлага, батлан хамгаалах, боловсролын салбар орж байгаагаас харахад хөдөөд боловсруулах зэрэг аж үйлдвэрийн салбар муу хөгжсөнийг гэрчилнэ. Харин уул уурхай, олборлолтын салбарт ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь хот, хөдөөд ойролцоо гарсан нь тооллого явагдах үед уул уурхайн олборлохтой холбоотой үндсэн үйл ажиллагаа зогсож, ажил эрхэлдэг хүн ам нь хот суурин газар тоологдсоноос хамаарчээ.

## 3.4 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

### ХҮСНЭГТ 3.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

| Ажил мэргэжил | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | мян.хүн | эзлэх хувь | мян.хүн | эзлэх хувь | мян.хүн | эзлэх хувь |
| **АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ** | **911.7** | **100** | **495.1** | **100** | **416.6** | **100** |
| Менежер | 72.2 | 7.9 | 41.1 | 8.3 | 31.1 | 7.5 |
| Мэргэжилтэн | 153.9 | 16.9 | 53.2 | 10.8 | 100.7 | 24.2 |
| Техникч болон туслах/дэд мэргэжилтэн | 40.5 | 4.4 | 15.4 | 3.1 | 25 | 6 |
| Контор, үйлчилгээний ажилтан | 23.7 | 2.6 | 6.7 | 1.3 | 17.1 | 4.1 |
| Худалдаа үйлчилгээний ажилтан | 134.2 | 14.7 | 53.3 | 10.8 | 80.9 | 19.4 |
| Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан | 236.3 | 25.9 | 135.6 | 27.4 | 100.7 | 24.2 |
| Үйлдвэрлэл, барилга, гар урлал,холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 85 | 9.3 | 63.2 | 12.8 | 21.8 | 5.2 |
| Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч | 79.7 | 8.7 | 74 | 14.9 | 5.7 | 1.4 |
| Энгийн ажил мэргэжил | 68.7 | 7.5 | 36.7 | 7.4 | 32 | 7.7 |
| Зэвсэгт хүчний ажил, мэргэжил | 17.4 | 1.9 | 16 | 3.2 | 1.4 | 0.3 |

Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, хөдөө аж ахуй, ой, загас агнуур, энгийн ажил мэргэжил ажээ. Харин суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний алба болон биеийн хүч шаардсан ажил мэргэжлийн 90.0-ээс дээш хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Гэтэл мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтай 10 хүн тутмын 7 нь эмэгтэйчүүд байна.

### ХҮСНЭГТ 3.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

| | 2000 | | | 2010 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Цалин хөлстэй ажиллагч | 41.3 | 39.3 | 43.6 | 56.2 | 53.6 | 59.4 |
| Ажил олгогч | 1.3 | 1.7 | 0.8 | 2.5 | 3.1 | 1.8 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 31.2 | 43.9 | 16.4 | 27.7 | 37.7 | 15.9 |
| Нөхөрлөл, хоршооны гишүүн | 0.5 | 0.5 | 0.4 | 0.2 | 0.2 | 0.2 |
| Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч | 25.3 | 14 | 38.6 | 12.9 | 4.9 | 22.5 |
| Бусад | 0.4 | 0.6 | 0.2 | 0.4 | 0.5 | 0.3 |

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлчийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2000 онд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 197.5 мянган хүн байсан бол 2010 онд 117.8 мянга болтлоо цөөрсөн байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин 3.5 пунктээр буурч, харин цалин хөлстэй ажиллагч, ажил олгогчийн хувийн жин өссөн нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөнийг харуулна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувийн жин буурах нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай юм. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус)-д өөрчлөлт гарсан байна.

Тооллогоор 15, түүнээс дээш насны бүх хүмүүсийн гэрлэлтийн байдлыг огт гэр бүл болоогүй, батлуулсан гэр бүлтэй, батлуулаагүй гэр бүлтэй, тусгаарласан, цуцалсан, бэлбэсэн гэсэн 6 бүлэгт хувааж авч үзсэн.

Зураг 3.3-т хүн ам орон сууцны 2000 он болон 2010 оны гэрлэлтийн байдлын талаарх асуултын бүтцийг харууллаа.

## ЗУРАГ 3.3 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2000, 2010 ОН

| 2000 он |
|---|
| 1. Огт гэр бүл болоогүй |
| 2. Гэрлэсэн |
| 3. Хамт амьдардаг |
| 4. Тусгаарласан |
| 5. Цуцалсан |
| 6. Бэлбэсэн |

| 2010 он |
|---|
| 1. Огт гэр бүл болоогүй |
| 2. Батлуулсан гэр бүлтэй |
| 3. Батлуулаагүй гэр бүлтэй |
| 4. Тусгаарласан |
| 5. Цуцалсан |
| 6. Бэлбэсэн |

Монгол улсын 15, түүнээс дээш насны нийт хүн амын 60.5 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 26.1 хувь нь огт гэр бүл болоогүй, 2.9 хувь нь бэлбэсэн байна.

## ХҮСНЭГТ 3.8 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010 ОН

| Гэрлэлтийн байдал | 2000 он | | | 2010 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Огт гэр бүл болоогүй | 26.1 | 29.5 | 22.2 | 19.7 | 22.3 | 16.5 |
| Батлуулсан гэр бүлтэй | 60.5 | 59.9 | 61.3 | 64.9 | 64.9 | 64.8 |
| Батлуулаагүй гэр бүлтэй | 7.7 | 7.6 | 7.8 | 9.4 | 9.4 | 9.4 |
| Тусгаарласан | 1.2 | 0.8 | 1.6 | 1.4 | 1.0 | 1.8 |
| Цуцалсан | 1.6 | 1.0 | 2.4 | 2.1 | 1.4 | 2.9 |
| Бэлбэсэн | 2.9 | 1.3 | 4.7 | 2.6 | 1.0 | 4.6 |

Гэрлэлтийн байдлыг хүйсээр 2000 онтой харьцуулж авч үзэхэд бэлбэсэн, огт гэр бүл болоогүй шалтгаанаар эрэгтэйчүүд 0.4-7.1 пунктээр буурсан бол харин тусгаарласан, цуцалсан, батлуулаагүй болон батлуулсан гэр бүлтэй хүний тоо 0.2-5.0 пунктээр өсчээ. Бэлбэсэн, огт гэр бүл болоогүй шалтгаанаар эмэгтэйчүүд 0.1-5.7 пунктээр буурч харин тусгаарласан, цуцалсан, батлуулаагүй болон батлуулсан гэр бүлтэй хүний тоо 0.2-3.6 пунктээр өсчээ.

## ХҮСНЭГТ 3.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

| Гэрлэлтийн байдал | 2000 он | | | 2010 он | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **779151** | **420426** | **358725** | **911 664** | **495 101** | **416 563** | **117.0** |
| Огт гэр бүл болоогүй | 203654 | 123866 | 79788 | 179 217 | 110 515 | 68 702 | 88.0 |
| Батлуулсан гэр бүлтэй | 471521 | 251724 | 219797 | 591 505 | 321 373 | 270 132 | 125.4 |
| Батлуулаагүй гэр бүлтэй | 59889 | 31786 | 28103 | 85 571 | 46 566 | 39 005 | 142.9 |
| Тусгаарласан | 9177 | 3410 | 5767 | 12 385 | 4 932 | 7 453 | 135.0 |
| Цуцалсан | 12690 | 4130 | 8560 | 18 975 | 6 972 | 12 003 | 149.5 |
| Бэлбэсэн | 22220 | 5510 | 16710 | 24 011 | 4 743 | 19 268 | 108.1 |

Гэрлэлтийн байдлыг 2000 онтой харьцуулбал бэлбэсэн 8.1 хувь, батлуулсан гэр бүлтэй 25.4 хувь, тусгаарласан 35.0 хувь, батлуулаагүй гэр бүлтэй 42.9 хувь, цуцалсан 49.5 хувиар тус тус өсч, харин огт гэр бүл болоогүй ажил эрхэлдэг хүн амын тоо 12.0 хувиар буурсан дүнтэй байна.

## ХҮСНЭГТ 3.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

| Боловсролын түвшин | 2000 он | | | 2010 он | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Дээд | 12.3 | 11.2 | 13.4 | 29.2 | 23.5 | 36.0 | 238.4 |
| Тусгай мэргэжлийн дунд | 10.7 | 7.4 | 14.6 | 7.4 | 5.7 | 9.4 | 69.0 |
| Техник болон мэргэжлийн | 5.0 | 5.2 | 4.8 | 3.6 | 3.8 | 3.4 | 72.5 |
| Бүрэн дунд | 21.6 | 19.8 | 23.8 | 31.4 | 32.9 | 29.6 | 145.2 |
| Суурь | 30.6 | 34.0 | 26.7 | 16.2 | 19.0 | 12.9 | 53.0 |
| Бага | 15.7 | 17.7 | 13.3 | 8.6 | 10.6 | 6.3 | 55.0 |
| Боловсролгүй | 4.1 | 4.6 | 3.4 | 3.5 | 4.4 | 2.4 | 86.4 |

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын эзэмшсэн боловсролын түвшинг хүснэгт 3.10-т харууллаа. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын 96.5 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 95.6 хувь, эмэгтэйчүүдийн 97.6 хувь нь ямар нэг түвшний боловсрол эзэмшжээ. Ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн 23.5 хувь нь дээд боловсролтой байхад ижил түвшний боловсролтой эмэгтэйчүүдийн хувь 12.5 пунктээр илүү байна. 2000 онтой харьцуулахад дээд боловсролтой хүмүүсийн тоо 2.8 дахин өсчээ. Боловсролгүй ажил эрхэлдэг хүн амын тоо эзлэх хувь 2000 оноос 0.6 пунктээр буурсан нь сүүлийн 10 жилд хүмүүсийн сурч боловсрох эрмэлзэл өссөнтэй холбоотой.

## 3.5 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙН БАЙДЛААР, 2010 ОНЫ ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР

Зураг 3.4-т ажиллагчдыг шилжих хөдөлгөөнд ороогүй, 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон гэсэн 3 үзүүлэлтээр авч үзэв. Монгол Улсад 15 ба түүнээс дээш насны 911.6 мянган хүн ам амьдарч байгаагаас 45.1 хувь нь шилжих хөдөлгөөнд ороогүй, 50.4 хувь нь 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 4.5 хувь нь 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон байв.

### ЗУРАГ 3.4 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН




Тав хүртэлх насны хүүхдүүд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул шилжих хөдөлгөөнийг тодорхой хугацааны аргаар (таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар) тодорхойлоход зөвхөн тав, түүнээс дээш насны хүн амыг оруулсан. Ажил эрхэлж байгаа хүн амын 411.5 мян.хүн буюу 45.1 хувь нь шилжих хөдөлгөөнд ороогүй, 373.3 мян.хүн буюу 40.9 хувь нь 2005 оны 1 дүгээр сараас хойш шилжих хөдөлгөөнд ороогүй, 126.8 мян.хүн буюу 13.9 хувь нь 2005 оны 1 дүгээр сараас хойш шилжих хөдөлгөөнд орсон хүмүүс байна. (Зураг 3.5 )

### ЗУРАГ 3.5 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОНЫ ТООЛЛОГООР



## 3.6 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, 2010 ОНЫ ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР

Монгол Улсын хэмжээнд арван тав ба түүнээс дээш насны 911.7 мянган ажил эрхэлдэг хүн амын 892.0 мянга нь буюу 97.8 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлгүй, 19.7 мянга буюу 2.2 хувь нь ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй гэж тоологджээ. (Зураг 3.6)

### ЗУРАГ 3.6 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




Ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 19657 иргэний 63.0 хувь буюу 12380 мянга нь эрэгтэй, 37.0 хувь 7277 мянга эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл 27.5 хувь нь хөдөлгөөний, 21.9 хувь нь харааны, 17.6 хувь нь бусад, 17.0 хувь нь сонсголын, 10.7 хувь нь сэтгэцийн, 5.2 хувь нь ярианы бэрхшээлтэй иргэд байна.(Зураг 3.7)

### ЗУРАГ 3.7 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны ангиллаар нь авч үзвэл 15, түүнээс дээш насанд өссөөр 45-49 насанд хамгийн өндөр үзүүлэлттэй байна. (Зураг 3.8)

ЗУРАГ 3.8 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## АЖИЛГҮЙ ИРГЭД



## 4.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Хүн амын эдийн засгийн идэвхийн талаарх ойлголт, тодорхойлолтыг НҮБ-ын “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж-2”-ын 2.252 хэсгийг үндэслэн сүүлийн хоёр тооллогод хэрэглэлээ. Тиймээс хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг тодорхойлж, хоёр тооллогын үр дүнг зэрэгцүүлэх боломжтой болсон. Үндэсний Статистикийн Хорооны дарга, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2009 оны 01-681/94 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” болон ОУХБ-аас зөвлөмж болгож буй ажилгүй иргэдийн талаарх тодорхойлолт нь ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа гэсэн 3 үндсэн шалгуур үзүүлэлтэнд тулгуурладаг.

**“Ажилгүй иргэн”** гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

а. **“ажилгүй байсан”** гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхлэж орлого олоогүй байхыг;

б. **“ажил хийхэд бэлэн”** гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в. **“ажил идэвхтэй хайж байгаа”** гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хөдөлмөр эрхлэхгүй байгаа гэж хариулсан хүмүүсээс зөвхөн хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгааныг тодруулан асуусан. Асуултын бүтцийг Зураг 4.1-т харууллаа.

ЗУРАГ 4.1. АЖИЛГҮЙ ИРГЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТ, 2010 ОН



Тооллогын өмнөх 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй байгаа гэж хариулсан гэхдээ хөдөлмөр эрхлээгүй байгаа шалтгаанаа **"Ажил хайж байгаа"** гэж хариулсан хүнийг ажилгүй иргэдэд хамруулсан. Учир нь дээрх 8 шалтгаанаар хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүмүүсээс зөвхөн "Ажил хайж байгаа" иргэд л ажилгүй иргэний шалгуурыг хангаж байгаа юм. Бусад шалтгаантай иргэд нь эдийн засгийн идэвхгүй иргэдэд тооцогдоно.

## 4.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, БҮСЭЭР

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр сүүлийн 7 хоногт ажил эрхлэх боломжтой, ажил хайсан ажилгүй иргэдийн тоо 164116 байгаагийн 57.9 хувь буюу 95031 нь эрэгтэй, 42.1 хувь буюу 69085 нь эмэгтэйчүүд байна.

### ХҮСНЭГТ 4.1 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, БҮС, ХҮЙСЭЭР, 2000Ь 2010 ОН

| Байршил, бүс нутаг | 2000 | | | | | | 2010 | | | | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Хүйсээр | | | | Бүгд | | Хүйсээр | | | | |
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | | | | Эрэгтэй | | Эмэгтэй | | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % | Тоо | % | |
| **БҮГД** | **164.9** | **100.0** | **93.8** | **100.0** | **71.2** | **100.0** | **164.1** | **100.0** | **95.0** | **100.0** | **69.1** | **100.0** | **99.5** |
| Хот | 117.8 | 71.4 | 67.9 | 72.4 | 49.9 | 70.1 | 114.6 | 69.8 | 65.9 | 69.4 | 48.6 | 70.4 | 97.2 |
| Хөдөө | 47.1 | 28.6 | 25.8 | 27.5 | 21.3 | 29.9 | 49.5 | 30.2 | 29.1 | 30.6 | 20.4 | 29.6 | 105.2 |
| | | | | | | | | | | | | | |
| Төв | 33.3 | 20.2 | 18.4 | 19.6 | 14.9 | 20.9 | 30.2 | 18.4 | 17.6 | 18.5 | 12.6 | 18.2 | 90.7 |
| Зүүн | 18.2 | 11.0 | 9.6 | 10.2 | 8.6 | 12.1 | 13.7 | 8.3 | 7.8 | 8.2 | 5.9 | 8.5 | 75.2 |
| Баруун | 25.1 | 15.2 | 14.0 | 14.9 | 11.1 | 15.6 | 23.2 | 14.1 | 13.2 | 13.9 | 10.0 | 14.5 | 92.5 |
| Хангай | 32.8 | 19.9 | 18.3 | 19.5 | 14.6 | 20.5 | 36.3 | 22.1 | 20.7 | 21.8 | 15.6 | 22.5 | 110.7 |
| Улаанбаатар | 55.6 | 33.7 | 33.5 | 35.8 | 22.0 | 31.0 | 60.7 | 37.0 | 35.7 | 37.6 | 25.0 | 36.3 | 109.3 |

Улсын хэмжээнд ажилгүй иргэдийн тоо 2010 онд 164.1 мянган хүн байгаа нь 2000 оноос 0.8 мянган хүнээр буюу дөнгөж 1 хувиар буурчээ.

Арван тав ба түүнээс дээш насны хүн амд ажилгүй иргэдийн эзлэх хувь 2000 оныхоос улсын хэмжээнд 2.2 пунктээр буурсан байна. Бүс нутгаар авч үзвэл Баруун бүсэд өмнөх тооллоготой ижил түвшинд, Хангайн бүсэд 0.4 пунктээр өсч, Төвийн болон Улаанбаатар, Зүүн бүсэд 2.3-3.9 пунктээр буурсан байна.

### ХҮСНЭГТ 4.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010 ОНООР, ХҮЙС, БҮС НУТГААР

| Бүс | 2000 он | | | 2010 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| **БҮГД*** | **10.8** | **12.5** | **7.8** | **8.6** | **10.1** | **7.1** |
| Баруун бүс | 10.0 | 11.2 | 8.4 | 10.0 | 11.5 | 8.6 |
| Хангайн бүс | 9.8 | 11.0 | 7.8 | 10.2 | 11.7 | 8.7 |
| Төвийн бүс | 11.9 | 13.0 | 9.9 | 9.6 | 10.7 | 8.3 |
| Зүүн бүс | 14.4 | 15.2 | 13.0 | 10.5 | 11.8 | 9.2 |
| Улаанбаатар | 10.5 | 13.2 | 5.9 | 7.0 | 8.6 | 5.5 |

**15 ба түүнээс дээш насны хүнд ам ажилгүй иргэдийн эзлэх хувь*

Нийт ажилгүй иргэдийн 70 гаруй хувь нь хот, суурин газарт төвлөрчээ. Харин ажилгүйдлийн түвшин 2010 онд 2000 оныхоос 2.2 пунктээр буурсны дотор хотод 7.8 пунктээр буурч, хөдөөд 2.8 пунктээр нэмэгдсэн байна. Нийт ажилгүй иргэдийн 37.0 хувь буюу 60732 ажилгүй хүн Улаанбаатар хотод амьдарч байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин ч өндөр гарчээ.

Ажилгүй иргэдийн тоог бүс нутгаар авч үзвэл ажилгүй таван хүний нэг нь хангайн бүсэд, нийт ажилгүй иргэдийн 8.3 хувь нь зүүн бүсэд амьдарч байна.

## ХҮСНЭГТ 4.3 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

| Насны бүлэг | 2000 он | | | | | 2010 он | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Хот | Хөдөө | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Хот | Хөдөө |
| **БҮГД** | **17.5** | **18.2** | **16.6** | **24.4** | **10.2** | **15.3** | **16.1** | **14.2** | **16.5** | **13.0** |
| 15-19 | 25.5 | 24.4 | 27.2 | 48.7 | 13.7 | 31.0 | 27.8 | 38.2 | 39.5 | 22.9 |
| 20-24 | 21.0 | 21.5 | 20.4 | 32.8 | 11.2 | 23.8 | 22.9 | 25.0 | 24.8 | 21.8 |
| 25-29 | 18.5 | 19.7 | 17.0 | 26.4 | 10.0 | 16.5 | 16.6 | 16.5 | 17.5 | 14.6 |
| 30-34 | 18.4 | 19.0 | 17.8 | 23.9 | 11.4 | 15.2 | 16.0 | 14.3 | 16.5 | 12.8 |
| 35-39 | 16.9 | 18.2 | 15.5 | 20.5 | 11.4 | 14.0 | 15.5 | 12.3 | 15.2 | 11.7 |
| 40-44 | 14.0 | 15.7 | 12.3 | 17.2 | 9.2 | 12.5 | 14.1 | 10.9 | 13.6 | 10.6 |
| 45-49 | 10.6 | 13.0 | 7.6 | 13.7 | 6.2 | 10.4 | 12.3 | 8.6 | 11.3 | 8.7 |
| 50-54 | 7.0 | 9.6 | 2.5 | 9.4 | 3.9 | 7.1 | 9.4 | 4.4 | 8.1 | 5.3 |
| 55-59 | 4.5 | 5.8 | 0.9 | 7.9 | 1.8 | 4.5 | 6.0 | 1.2 | 5.8 | 2.5 |
| 60+ | 0.8 | 0.7 | 1.0 | 2.1 | 0.3 | 0.5 | 0.5 | 0.4 | 0.7 | 0.2 |

Монгол Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин нийт ажиллах хүчний 15.3 хувьд хүрч, эрэгтэйчүүдийн (16.1) хувьд эмэгтэйчүүдийнхээс (14.2) бага зэрэг дээгүүр байгаа юм. Ажилгүйдлийн түвшин дүнгээрээ хотод (16.5), хөдөөгийнхөөс(13.0) харьцангуй өндөр байгаагийн дотор энэ нь эрэгтэйчүүд (хотын эрэгтэй 17.7 хувь, хөдөөгийнх 13.4 хувь), эмэгтэйчүүдийн (хотын эмэгтэй 15.0 хувь, хөдөөгийнх-12.6 хувь) хувьд ч адил байна.

## ЗУРАГ 4.2 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, 2000, 2010 ОН



Ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас сүүлийн жилүүдэд мал аж ахуйн үйлдвэрлэлд тохиолдсон байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан олон тооны өрх малгүй болж, хот суурин газарт шилжин ирж байгаа, нөгөө талаас тэд хотод ирээд ажлын байр олох боломж нөхцөл муу байдагтай холбоотой.

Нийт ажилгүй хүмүүсийн дотор 20-34 насны 95.1 мянган (ажилгүй иргэдийн 57.9 хувь) залуучууд байгаа нь бусад насны хамгийн өндөр юм. Харин 35-44 насны 39.2 мянган хүн ажилгүй байгаа нь нийт ажилгүйчүүдийн 23.9 хувь болж байна. Үүнээс үзэхэд ажилгүй иргэдийн дийлэнх нь буюу 63.1 хувь нь 20-44 насныхан ажээ.

Дээд боловсролтой ажилгүй иргэдийн тоо өмнөх тооллогынхоос үр дүнтэй харьцуулбал 3.5 дахин өсчээ. Мөн боловсролгүй ажилгүй иргэдийн тоо 53.5 хувь, суурь боловсролтой 25.5 хувь, бага боловсролтой 5.7 хувиар өсчээ. Харин суурь боловсролтой ажилгүй иргэдийн тоо 46.7 хувь, тусгай мэргэжлийн дунд 39.2 хувь, техник болон мэргэжлийн боловсролтой ажилгүй иргэдийн тоо 34.4 хувиар тус тус буурчээ.(Хүснэгт 4.4 )

ХҮСНЭГТ 4.4. АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР 2000, 2010 ОН

| Боловсролын түвшин | 2000 он | | | 2010 он | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **164932** | **93770** | **71162** | **164116** | **95031** | **69085** | **99.5** |
| Дээд | 8022 | 4073 | 3949 | 28401 | 11365 | 17036 | 354.0 |
| Тусгай мэргэжлийн дунд | 12912 | 5405 | 7507 | 7847 | 4000 | 3847 | 60.8 |
| Техник болон мэргэжлийн | 10670 | 6068 | 4602 | 7004 | 4016 | 2988 | 65.6 |
| Бүрэн дунд | 55408 | 27891 | 27517 | 69561 | 40728 | 28833 | 125.5 |
| Суурь | 62493 | 39968 | 22525 | 33292 | 22161 | 11131 | 53.3 |
| Бага | 11868 | 8008 | 3860 | 12547 | 8872 | 3675 | 105.7 |
| Боловсролгүй | 3559 | 2357 | 1202 | 5464 | 3889 | 1575 | 153.5 |

## 4.3 АЖИЛГҮЙ ИРГЭД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОНЫ ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР

Зураг 4.3-т ажилгүй иргэдийг шилжих хөдөлгөөнд ороогүй, 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон гэсэн 3 үзүүлэлтээр авч үзлээ. Монгол Улсад 15 ба түүнээс дээш насны 164.1 мянган хүн ам амдарч байгаагаас 53.0 хувь нь шилжих хөдөлгөөнд ороогүй, 41.1 хувь нь 2010 оноос өмнө шилжих хөдөлгөөнд орсон, 5.9 хувь нь 2010 онд шилжих хөдөлгөөнд орсон байв.

ЗУРАГ 4.3 АЖИЛГҮЙ ИРГЭД, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010 ОН



## 4.4 АЖИЛГҮЙ ИРГЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОНЫ ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР

Монгол Улсын хэмжээнд арван тав ба түүнээс 164.1 мянган ажилгүй иргэдийн 161.2 мянга нь буюу 98.2 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлгүй, 2.9 мянга буюу 1.8 хувь нь ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй гэж тоологджээ. (Зураг 4.4)

### ЗУРАГ 4.4 АЖИЛГҮЙ ИРГЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл 25.3 хувь нь хөдөлгөөний, 23.2 хувь нь харааны, 19.9 хувь нь сонсголын, 16.2 хувь нь бусад, 9.9 хувь нь сэтгэцийн, 5.5 хувь нь ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.(Зураг 4.5)

### ЗУРАГ 4.5 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



## ХҮСНЭГТ 4.5 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010 ОН

| Насны бүлэг | Бүгд | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник болон мэргэжлийн | Бүрэн дунд | Суурь | Бага | Боловсролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **БҮГД** | **15.3** | **9.6** | **10.4** | **17.5** | **19.6** | **18.4** | **13.8** | **14.5** |
| 15-19 | 31.0 | 27.5 | 24.1 | 39.1 | 36.0 | 33.0 | 23.0 | 18.9 |
| 20-24 | 23.8 | 21.3 | 18.2 | 28.1 | 26.6 | 26.9 | 19.9 | 18.9 |
| 25-29 | 16.5 | 11.3 | 14.2 | 20.3 | 21.7 | 21.7 | 15.7 | 14.9 |
| 30-34 | 15.2 | 7.8 | 11.9 | 17.1 | 19.8 | 19.3 | 14.4 | 14.6 |
| 35-39 | 14.0 | 5.9 | 11.3 | 15.7 | 17.7 | 16.8 | 14.5 | 14.7 |
| 40-44 | 12.5 | 4.8 | 10.6 | 14.2 | 15.8 | 15.3 | 12.6 | 10.7 |
| 45-49 | 10.4 | 4.4 | 8.8 | 12.5 | 13.7 | 13.4 | 10.0 | 9.8 |
| 50-54 | 7.1 | 3.5 | 5.8 | 8.7 | 10.3 | 9.1 | 6.1 | 6.6 |
| 55-59 | 4.5 | 2.1 | 4.3 | 6.5 | 8.3 | 6.1 | 2.9 | 3.9 |
| 60+ | 0.5 | 0.2 | 0.8 | 1.0 | 1.3 | 0.9 | 0.2 | 0.3 |
| **ЭРЭГТЭЙ** | **16.1** | **8.9** | **12.4** | **17.5** | **20.0** | **19.0** | **14.5** | **15.0** |
| 15-19 | 27.8 | 25.4 | 17.2 | 34.8 | 33.0 | 30.3 | 21.3 | 17.5 |
| 20-24 | 22.9 | 18.1 | 15.4 | 26.3 | 25.7 | 26.9 | 20.6 | 20.0 |
| 25-29 | 16.6 | 9.9 | 13.2 | 17.4 | 20.7 | 22.5 | 16.6 | 15.0 |
| 30-34 | 16.0 | 7.7 | 12.5 | 16.4 | 19.5 | 20.5 | 14.7 | 14.1 |
| 35-39 | 15.5 | 6.3 | 14.1 | 16.1 | 18.8 | 17.4 | 14.4 | 15.1 |
| 40-44 | 14.1 | 5.5 | 13.8 | 14.6 | 17.1 | 15.8 | 12.9 | 11.7 |
| 45-49 | 12.3 | 5.3 | 11.3 | 13.9 | 15.5 | 14.1 | 11.0 | 10.8 |
| 50-54 | 9.4 | 4.8 | 9.1 | 11.5 | 12.7 | 10.9 | 7.4 | 7.4 |
| 55-59 | 6.0 | 2.9 | 6.9 | 7.7 | 10.0 | 7.5 | 3.7 | 5.0 |
| 60+ | 0.5 | 0.3 | 1.1 | 1.3 | 1.4 | 0.8 | 0.1 | 0.6 |
| **ЭРЭГТЭЙ** | **14.2** | **10.2** | **8.9** | **17.4** | **19.0** | **17.2** | **12.3** | **13.4** |
| 15-19 | 38.2 | 29.8 | 39.4 | 45.6 | 41.1 | 40.8 | 29.2 | 23.2 |
| 20-24 | 25.0 | 23.6 | 23.0 | 31.2 | 28.2 | 26.9 | 18.2 | 16.0 |
| 25-29 | 16.5 | 12.4 | 15.4 | 24.8 | 23.1 | 20.4 | 14.0 | 14.6 |
| 30-34 | 14.3 | 7.9 | 11.4 | 18.1 | 20.2 | 17.6 | 13.8 | 15.9 |
| 35-39 | 12.3 | 5.6 | 9.2 | 15.2 | 16.4 | 15.7 | 14.9 | 14.0 |
| 40-44 | 10.9 | 4.4 | 8.7 | 13.9 | 14.4 | 14.4 | 12.0 | 9.2 |
| 45-49 | 8.6 | 3.7 | 7.5 | 11.1 | 11.7 | 12.3 | 8.4 | 8.4 |
| 50-54 | 4.4 | 2.5 | 3.9 | 4.7 | 6.9 | 5.5 | 4.1 | 5.3 |
| 55-59 | 1.2 | 0.6 | 0.9 | 1.9 | 3.2 | 1.1 | 1.2 | 1.3 |
| 60+ | 0.4 | 0.1 | 0.2 | - | 1.0 | 1.0 | 0.4 | - |

## ХҮСНЭГТ 4.6 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН,НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, ХУВИАР, 2010 ОН

| Насны бүлэг | Бүгд | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник болон мэргэжлийн | Бүрэн дунд | Суурь | Бага | Боловсролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ХОТ** | **16.5** | **9.2** | **10.9** | **18.0** | **20.4** | **25.8** | **29.9** | **35.1** |
| 15-19 | 39.5 | 28.6 | 24.4 | 38.2 | 38.2 | 44.4 | 45.6 | 43.1 |
| 20-24 | 24.8 | 20.1 | 16.9 | 26.7 | 26.8 | 32.3 | 37.9 | 40.2 |
| 25-29 | 17.5 | 10.9 | 13.8 | 19.4 | 21.9 | 28.2 | 34.1 | 35.6 |
| 30-34 | 16.5 | 7.9 | 12.4 | 17.5 | 20.6 | 27.4 | 33.6 | 35.4 |
| 35-39 | 15.2 | 5.9 | 11.9 | 17.5 | 19.1 | 25.9 | 34.3 | 36.8 |
| 40-44 | 13.6 | 4.9 | 11.2 | 15.6 | 16.9 | 23.1 | 23.6 | 28.3 |
| 45-49 | 11.3 | 4.5 | 9.5 | 13.0 | 14.6 | 19.7 | 19.2 | 25.9 |
| 50-54 | 8.1 | 3.6 | 6.4 | 8.7 | 11.2 | 13.1 | 16.3 | 22.7 |
| 55-59 | 5.8 | 2.1 | 4.7 | 7.2 | 9.8 | 10.5 | 10.2 | 12.1 |
| 60+ | 0.7 | 0.2 | 0.7 | 1.5 | 2.0 | 2.0 | 0.6 | 2.5 |
| **ЭРЭГТЭЙ** | **17.7** | **8.6** | **12.7** | **18.0** | **20.7** | **25.7** | **29.9** | **34.6** |
| 15-19 | 37.7 | 27.1 | 19.2 | 34.9 | 36.7 | 42.7 | 42.2 | 41.0 |
| 20-24 | 24.0 | 17.2 | 14.9 | 24.6 | 25.8 | 30.9 | 36.2 | 39.7 |
| 25-29 | 17.3 | 9.6 | 12.6 | 16.7 | 20.4 | 26.7 | 32.8 | 34.3 |
| 30-34 | 17.5 | 7.6 | 12.9 | 16.2 | 20.0 | 27.0 | 32.6 | 33.0 |
| 35-39 | 17.3 | 6.2 | 14.4 | 17.6 | 20.1 | 26.5 | 33.7 | 35.9 |
| 40-44 | 15.9 | 5.5 | 14.1 | 15.8 | 18.6 | 24.0 | 25.1 | 29.1 |
| 45-49 | 13.7 | 5.4 | 11.6 | 15.0 | 16.5 | 20.4 | 20.5 | 26.6 |
| 50-54 | 10.8 | 4.8 | 9.6 | 11.7 | 13.7 | 14.6 | 17.9 | 25.3 |
| 55-59 | 7.8 | 3.0 | 7.5 | 8.7 | 11.9 | 12.4 | 11.5 | 12.5 |
| 60+ | 0.8 | 0.3 | 1.3 | 1.9 | 2.2 | 1.7 | 0.0 | 4.3 |
| **ЭРЭГТЭЙ** | **15.0** | **9.7** | **9.4** | **18.0** | **20.0** | **26.1** | **29.8** | **36.3** |
| 15-19 | 42.9 | 30.2 | 35.0 | 43.6 | 40.4 | 48.4 | 57.4 | 51.4 |
| 20-24 | 25.9 | 22.3 | 20.8 | 30.9 | 28.7 | 35.9 | 43.5 | 42.2 |
| 25-29 | 17.7 | 12.1 | 15.7 | 24.6 | 24.5 | 31.7 | 38.0 | 39.1 |
| 30-34 | 15.3 | 8.1 | 11.9 | 19.7 | 21.5 | 28.0 | 36.7 | 42.6 |
| 35-39 | 12.9 | 5.7 | 9.9 | 17.3 | 17.8 | 24.7 | 35.6 | 38.6 |
| 40-44 | 11.3 | 4.5 | 9.3 | 15.4 | 15.1 | 21.4 | 21.1 | 26.8 |
| 45-49 | 9.1 | 3.8 | 8.2 | 10.8 | 12.5 | 18.5 | 17.0 | 24.4 |
| 50-54 | 5.2 | 2.6 | 4.5 | 4.9 | 7.7 | 9.6 | 13.2 | 18.8 |
| 55-59 | 1.7 | 0.6 | 1.2 | 2.2 | 3.8 | 2.2 | 6.4 | 10.7 |
| 60+ | 0.6 | 0.1 | 0.0 | 0.0 | 1.5 | 2.8 | 1.3 | 0.0 |

## ХҮСНЭГТ 4.7 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН,НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, ХУВИАР, 2010 ОН

| Насны бүлэг | Бүгд | Дээд | Тусгай мэргэжлийн дунд | Техник болон мэргэжлийн | Бүрэн дунд | Суурь | Бага | Боловсролгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ХӨДӨӨ** | **13.0** | **12.3** | **9.0** | **16.8** | **17.2** | **13.3** | **9.3** | **9.6** |
| 15-19 | 22.9 | 16.7 | 23.2 | 40.3 | 31.2 | 25.1 | 15.7 | 13.1 |
| 20-24 | 21.8 | 26.8 | 23.2 | 30.2 | 26.0 | 21.9 | 14.2 | 12.9 |
| 25-29 | 14.6 | 13.3 | 15.4 | 21.9 | 20.8 | 16.6 | 10.9 | 10.1 |
| 30-34 | 12.8 | 7.7 | 9.9 | 16.3 | 17.2 | 13.9 | 10.0 | 9.6 |
| 35-39 | 11.7 | 5.7 | 9.5 | 13.6 | 14.1 | 11.7 | 9.0 | 8.8 |
| 40-44 | 10.6 | 4.6 | 9.2 | 12.7 | 13.0 | 10.7 | 8.0 | 6.7 |
| 45-49 | 8.7 | 3.9 | 7.2 | 12.1 | 11.1 | 9.1 | 6.9 | 6.3 |
| 50-54 | 5.3 | 3.0 | 4.2 | 8.6 | 7.7 | 6.2 | 3.5 | 3.3 |
| 55-59 | 2.5 | 2.0 | 3.3 | 5.6 | 4.1 | 2.9 | 1.3 | 2.4 |
| 60+ | 0.2 | - | 0.8 | 0.6 | - | 0.3 | 0.1 | - |
| **ЭРЭГТЭЙ** | **13.4** | **11.1** | **11.1** | **16.8** | **17.8** | **14.0** | **9.9** | **9.9** |
| 15-19 | 19.5 | 12.5 | 11.6 | 34.8 | 25.6 | 22.5 | 14.6 | 11.5 |
| 20-24 | 21.0 | 22.4 | 17.8 | 29.3 | 25.6 | 22.9 | 15.0 | 13.7 |
| 25-29 | 15.1 | 12.0 | 16.6 | 19.3 | 22.0 | 18.5 | 11.7 | 10.3 |
| 30-34 | 13.2 | 8.9 | 10.2 | 17.1 | 17.5 | 15.0 | 10.2 | 9.3 |
| 35-39 | 12.3 | 7.1 | 13.2 | 14.1 | 14.9 | 12.0 | 8.9 | 9.4 |
| 40-44 | 11.1 | 5.6 | 12.8 | 13.2 | 13.2 | 10.9 | 8.1 | 7.4 |
| 45-49 | 9.8 | 4.8 | 10.5 | 12.7 | 12.5 | 9.6 | 7.7 | 6.8 |
| 50-54 | 7.1 | 4.5 | 7.5 | 11.3 | 9.9 | 8.0 | 4.4 | 3.7 |
| 55-59 | 3.4 | 2.5 | 5.5 | 6.5 | 4.9 | 3.8 | 1.8 | 3.4 |
| 60+ | 0.2 | - | 0.9 | 0.8 | - | 0.5 | 0.1 | - |
| **ЭРЭГТЭЙ** | **12.6** | **13.1** | **7.7** | **16.8** | **16.5** | **12.2** | **8.2** | **9.0** |
| 15-19 | 32.5 | 25.0 | 57.0 | 48.1 | 42.7 | 33.9 | 19.4 | 17.7 |
| 20-24 | 23.2 | 29.7 | 28.8 | 31.5 | 26.6 | 19.9 | 12.4 | 11.2 |
| 25-29 | 14.0 | 14.1 | 14.6 | 24.9 | 19.4 | 14.0 | 9.7 | 9.8 |
| 30-34 | 12.3 | 7.0 | 9.8 | 15.5 | 16.9 | 12.7 | 9.6 | 10.3 |
| 35-39 | 11.0 | 4.9 | 7.3 | 13.1 | 13.5 | 11.2 | 9.0 | 7.5 |
| 40-44 | 10.0 | 3.8 | 7.2 | 12.2 | 12.7 | 10.3 | 7.8 | 5.5 |
| 45-49 | 7.5 | 3.2 | 5.7 | 11.4 | 9.5 | 8.3 | 5.8 | 5.5 |
| 50-54 | 2.9 | 1.4 | 2.3 | 4.5 | 4.4 | 3.2 | 2.1 | 2.8 |
| 55-59 | 0.5 | 0.5 | 0.5 | 1.4 | 1.1 | 0.6 | 0.3 | - |
| 60+ | 0.1 | - | 0.6 | - | - | - | 0.2 | - |

# ТАВДУГААР БҮЛЭГ

## БҮС НУТГИЙН БОЛОН АЙМГИЙН ЯЛГАА






## 5.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Өмнөх бүлгүүдэд ажиллах хүчний оролцоо, ажилгүйдлийн түвшин болон ажиллах хүчний бүтэц хот, хөдөөгөөр ялгаатай байгаа нь тухай өгүүлсэн билээ. Янз бүрийн шалтгааны улмаас хүн амын эдийн засгийн идэвх бүс болон аймгаар ялгаатай байдаг.

Энэ бүлэгт эдгээр ялгаатай байдлын талаар танилцуулах болно.

## 5.2 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН БҮС, АЙМГИЙН ЯЛГАА

Хүснэгт 5.1-д арван тав ба түүнээс дээш насны хүн амын тоо, эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, ажиллах хүчний оролцооны түвшинг бүс нутаг, аймаг, нийслэл 2000, 2010 оноор харууллаа.

### ХҮСНЭГТ 5.1 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, 2000, 2010 ОН

| | 15, ба түүнээс дээш насны хүн ам | | Эдийн засгийн идэвхтэй хүн ам | | Ажиллах хүчний оролцооны түвшин (%) | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2000 | 2010 | 2000 | 2010 | 2000 | 2010 |
| **БҮГД** | **1524 372** | **1 905 969** | **944 083** | **1075780** | **61.9** | **56.4** |
| Баруун бүс | 250 700 | 231 103 | 171 188 | 134 019 | 68.3 | 58.0 |
| Баян-Өлгий | 62 035 | 53 720 | 32 906 | 29 107 | 69.9 | 54.2 |
| Говь-Алтай | 40 412 | 36 397 | 29 946 | 22 701 | 76.7 | 62.4 |
| Завхан | 55 990 | 44 045 | 39 553 | 25 918 | 69.6 | 58.8 |
| Увс | 55 513 | 46 976 | 35 462 | 28 384 | 69.7 | 60.4 |
| Ховд | 53 497 | 49 965 | 33 321 | 27 909 | 67.2 | 55.9 |
| Хангайн бүс | 335 573 | 357 340 | 235 324 | 220 594 | 70.1 | 61.7 |
| Архангай | 58 990 | 57 668 | 40 733 | 36 841 | 69.1 | 63.9 |
| Баянхонгор | 50 367 | 51 541 | 37 657 | 33 587 | 74.8 | 65.2 |
| Булган | 39 053 | 37 370 | 26 313 | 24 414 | 67.4 | 65.3 |
| Орхон | 45 413 | 63 516 | 28 321 | 35 897 | 62.4 | 56.5 |
| Өвөрхангай | 68 244 | 68 444 | 51 259 | 42 478 | 75.1 | 62.1 |
| Хөвсгөл | 73 506 | 78 801 | 51 041 | 47 377 | 69.4 | 60.1 |
| Төвийн бүс | 280 724 | 315 649 | 182 327 | 193 044 | 64.9 | 61.2 |
| Говьсүмбэр | 7 620 | 9 095 | 4 554 | 5 704 | 59.8 | 62.7 |
| Дархан-Уул | 54 492 | 66 624 | 29 742 | 34 988 | 54.6 | 52.5 |
| Дорноговь | 32 255 | 40 811 | 23 038 | 26 087 | 71.4 | 63.9 |
| Дундговь | 31 598 | 26 427 | 24 135 | 17 393 | 76.4 | 65.8 |
| Өмнөговь | 28 891 | 45 222 | 22 410 | 33 794 | 77.6 | 74.7 |
| Сэлэнгэ | 62 535 | 67 803 | 35 873 | 39 101 | 57.4 | 57.7 |
| Төв | 63 333 | 59 667 | 42 575 | 35 977 | 67.2 | 60.3 |
| Зүүн бүс | 126 130 | 130 017 | 80 228 | 75 868 | 63.6 | 58.4 |
| Дорнод | 47 302 | 48 987 | 26 620 | 26 098 | 56.3 | 53.3 |
| Сүхбаатар | 34 765 | 36 068 | 24 494 | 22 952 | 70.5 | 63.6 |
| Хэнтий | 44 063 | 44 962 | 29 114 | 26 818 | 66.1 | 59.6 |
| Улаанбаатар | 531 245 | 871 860 | 275 016 | 452 255 | 51.8 | 51.9 |

Хүн амын насны бүтэц, сургуульд хамрагдалтын ялгаа нь аймаг, нийслэл болон бүс бүрийн хүн амын эдийн засгийн идэвхтэй байдалд нөлөөлсөн байж болох юм. Ялангуяа хот суурин газрын хүн амын насны бүтэц, сургуульд хамрагдалт нилээд ялгаатай бөгөөд энэ нь бусдаас ялгаатай байгаа нь ажиллах хүчний оролцооны түвшинг харуулж байгаа юм. Ажиллах хүчний оролцооны түвшин Хангайн бүсэд (61.7) хамгийн өндөр дараа нь Төвийн (61.2), Зүүн (58.4), Баруун (58.0) бүс орж, харин Улаанбаатар хотод хамгийн доогуур (51.9) байна.

Ер нь ажиллах хүчний оролцооны түвшин Улаанбаатар хотод хамгийн бага байдаг байна. Тухайлбал хүснэгт 5.1-ээс харахад 2000 онд Улаанбаатар хотын хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 51.8 хувь буюу хамгийн бага байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд 2000 оныхоос бүх бүс болон аймагт буурчээ. Улсын дүнгээр 2000 оноос 2010 онд ажиллах хүчний оролцооны түвшин 3.9 пунктээр, Хангайн болон Баруун бүсэд хамгийн их буюу 8.4-10.3 пунктээр буурсан байна. Энэ нь уг 2 бүсийн хувьд дэд бүтэц муу, 2000 оноос хойш үйлдвэрийн газар нэмэж байгуулагдаагүй ажлын байр хомсдолтой, хот суурин газраас алслагдмал зэрэгтэй холбоотой байж болох юм. Хотын хүн амын эзлэх хувь өндөр байхад ажиллах хүчний оролцоо доогуур байна. Хотод суралцагчдын эзлэх хувь өндөр байгаа учраас эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог өсгөхөд нөлөөлж байна.

Гэвч Улаанбаатар хотын хүн амын хувьд ажиллах хүчний оролцооны түвшин 2000 оноос өссөн дүнтэй байна.

Зураг 5.1-ээс харахад Өмнөговь аймагт ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр 70.0-аас дээш хувьтай, харин Дорнод аймагт хамгийн бага буюу 53.3 хувь байна. Ажил эрхэлдэг хүн амын 63.8 хувь нь хот, суурин газарт байгаагийн зэрэгцээ хөдөлмөр эрхэлсэн хүний тоо бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна.

## ЗУРАГ 5.1 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН




Ажил эрхэлдэг хүн амын тоо өмнөх тооллогын дүнгээс Дорнод, Дорноговь, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул, Өмнөговь, Орхон аймаг болон Улаанбаатар хотод 11.2-78.4 хувиар өсч, харин Сүхбаатар, Булган, Хэнтий, Төв, Хөвсгөл, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Говь-Алтай, Ховд, Өвөрхангай, Дундговь, Завхан аймагт ажил эрхэлдэг хүн амын тоо 1.8-37.5 хувиар буурав.

## ХҮСНЭГТ 5.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР 2000, 2010 ОН

| Аймгийн нэр | 2000 | | | 2010 | | | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | |
| **БҮГД** | **779 151** | **420 426** | **358 725** | **911 664** | **495 101** | **416 563** | **117.0** |
| Архангай | 36 365 | 19 679 | 16 686 | 31 518 | 16 756 | 14 762 | 86.7 |
| Баян-Өлгий | 26 331 | 15 169 | 11 162 | 22 549 | 12 958 | 9 591 | 85.6 |
| Баянхонгор | 33 678 | 17 567 | 16 111 | 28 742 | 15 113 | 13 629 | 85.3 |
| Булган | 21 593 | 11 931 | 9 662 | 20 632 | 11 297 | 9 335 | 95.5 |
| Говь-Алтай | 26 633 | 13 993 | 12 640 | 20 495 | 11 074 | 9 421 | 77.0 |
| Дорноговь | 19 877 | 11 382 | 8 495 | 22 211 | 12 656 | 9 555 | 111.7 |
| Дорнод | 18 327 | 10 441 | 7 886 | 20 384 | 11 249 | 9 135 | 111.2 |
| Дундговь | 22 216 | 11 706 | 10 510 | 14 770 | 7 819 | 6 951 | 66.5 |
| Завхан | 33 443 | 18 169 | 15 274 | 20 905 | 11 306 | 9 599 | 62.5 |
| Өвөрхангай | 45 613 | 24 239 | 21 374 | 34 308 | 18 436 | 15 872 | 75.2 |
| Өмнөговь | 20 739 | 11 005 | 9 734 | 29 652 | 19 507 | 10 145 | 143.0 |
| Сүхбаатар | 20 066 | 11 456 | 8 610 | 19 696 | 11 095 | 8 601 | 98.2 |
| Сэлэнгэ | 25 352 | 14 796 | 10 556 | 31 560 | 17 487 | 14 073 | 124.5 |
| Төв | 35 226 | 20 513 | 14 713 | 30 833 | 17 540 | 13 293 | 87.5 |
| Увс | 30 239 | 16 920 | 13 319 | 24 323 | 13 459 | 10 864 | 80.4 |
| Ховд | 29 449 | 16 376 | 13 073 | 22 531 | 12 307 | 10 224 | 76.5 |
| Хөвсгөл | 44 551 | 23 785 | 20 766 | 38 827 | 20 774 | 18 053 | 87.2 |
| Хэнтий | 23 647 | 13 045 | 10 602 | 22 115 | 12 164 | 9 951 | 93.5 |
| Дархан-Уул | 21 969 | 11 673 | 10 296 | 29 100 | 15 749 | 13 351 | 132.5 |
| Улаанбаатар | 219 454 | 113 326 | 106 128 | 391 523 | 207 521 | 184 002 | 178.4 |
| Орхон | 20 705 | 11 216 | 9 489 | 30 247 | 16 210 | 14 037 | 146.1 |
| Говьсүмбэр | 3 678 | 2 039 | 1 639 | 4 743 | 2 624 | 2 119 | 129.0 |

## ЗУРАГ 5.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, ЭРХЭЛДЭГ АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР, 2010 ОН



Ажил мэргэжилийн хувьд хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил мэргэжил ихэнх хувийг эзэлж байна. Орхон, Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотод үйлдвэрлэл, барилга, гар урлал холбогдох ажил үйлчилгээний ажил эрхэлж байгаа хүний тоо бусад аймгаас өндөр байгаа бол худалдаа, үйлчилгээний мэргэжлийн ажил хийж байгаа хүний тоо Улаанбаатар хот болон Орхон, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь аймагт өндөр хувьтай байна.

### ЗУРАГ 5.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛААР, 2010 ОН




Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлчийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгдсөн байна. 2000 онд өрхийн бизнест цалин хөлсгүй ажилладаг 197.5 мянган хүн байсан бол 2010 онд 117.8 мянга болтлоо цөөрчээ. Аймгуудад хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувийн жин 3.5 пунктээр буурч, харин цалин хөлстэй ажиллагч, ажил олгогчийн хувийн жин өссөн нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжсөнийг харуулна.

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувийн жин буурах нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгааллалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай юм.

## 5.3 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШНИЙ АЙМАГ ХООРОНДЫН ЯЛГАА

### ХҮСНЭГТ 5.3 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШНИЙ АЙМАГ ХООРОНДЫН ЯЛГАА, АЙМАГ, БҮСЭЭР, 2000, 2010 ОН

| | Ажилгүй иргэд | | Ажилгүйдлийн түвшин (%) | |
|---|---|---|---|---|
| | 2000 | 2010 | 2000 | 2010 |
| **БҮГД** | **164 932** | **164 116** | **17.5** | **15.3** |
| Баруун бүс | 25 093 | 23 216 | 14.7 | 17.3 |
| Баян-Өлгий | 6 575 | 6 558 | 15.2 | 15.1 |
| Говь-Алтай | 3 313 | 2 206 | 10.7 | 7.1 |
| Завхан | 6 110 | 5 013 | 15.7 | 12.9 |
| Увс | 5 223 | 4 061 | 13.5 | 10.5 |
| Ховд | 3 872 | 5 378 | 10.8 | 15.0 |
| Хангайн бүс | 32 819 | 36 320 | 13.9 | 16.5 |
| Архангай | 4 368 | 5 323 | 10.7 | 14.4 |
| Баянхонгор | 3 979 | 4 845 | 10.6 | 14.4 |
| Булган | 4 720 | 3 782 | 17.9 | 15.5 |
| Орхон | 7 616 | 5 650 | 26.9 | 15.7 |
| Өвөрхангай | 5 646 | 8 170 | 11.0 | 19.2 |
| Хөвсгөл | 6 490 | 8 550 | 12.7 | 18.0 |
| Төвийн бүс | 33 270 | 30 175 | 18.2 | 15.6 |
| Говьсүмбэр | 876 | 961 | 19.2 | 16.8 |
| Дархан-Уул | 7 773 | 5 888 | 26.1 | 16.8 |
| Дорноговь | 3 161 | 3 876 | 13.7 | 14.9 |
| Дундговь | 1 919 | 2 623 | 8.0 | 15.1 |
| Өмнөговь | 1 671 | 4 142 | 7.5 | 12.3 |
| Сэлэнгэ | 10 521 | 7 541 | 29.3 | 19.3 |
| Төв | 7 349 | 5 144 | 17.3 | 14.3 |
| Зүүн бүс | 18 188 | 13 673 | 22.7 | 18.0 |
| Дорнод | 8 293 | 5 714 | 31.2 | 21.9 |
| Сүхбаатар | 4 428 | 3 256 | 18.1 | 14.2 |
| Хэнтий | 5 467 | 4 703 | 18.8 | 17.5 |
| Улаанбаатар | 55 562 | 60 732 | 20.2 | 13.4 |

Ажилгүй иргэдийн тоо сүүлийн 10 жилд Улаанбаатар хот болон Говьсүмбэр, Баянхонгор, Архангай, Дорноговь, Хөвсгөл, Дундговь, Ховд, Өвөрхангай аймагт 9.7-44.7 хувиар, Өмнөговь аймагт 2.5 дахин өссөн дүнтэй байна. Харин Баян-Өлгий, Хэнтий, Завхан, Булган, Увс, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Дорнод аймагт ажилгүй иргэдийн тоо 0.3-31.1 хувиар буурсан байна. 2000 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 2.2 пунктээр буурсан хэдий ч Дорноговь, Архангай, Баянхонгор, Ховд, Өмнөговь, Хөвсгөл, Дундговь, Өвөрхангай аймагт 1.2-8.2 пунктээр өсч, харин Баян-Өлгий, Говьсүмбэр, Хэнтий, Булган, Завхан, Төв, Увс, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Орхон аймагт 0.1-11.2 пунктээр буурчээ. Мөн Улаанбаатар хотод 6.8 пунктээр буурсан нааштай үр дүн гарсан байна.

## ЗУРАГ 4.2 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2000, 2010 ОН




Зураг 4.2-т ажилгүйдлийн түвшинг 2000, 2010 оноор харууллаа. Ажилгүйдлийн түвшин аймгуудаар авч үзвэл Дорнод аймагт хамгийн өндөр буюу 21.9 хувь, Говь-Алтай аймагт хамгийн бага буюу 7.1 хувьтай байна.

# ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



Хүн ам, орон сууцны тооллогын хувьд Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн идэвхийн байдлын талаарх энэхүү сэдэвчилсэн судалгаа нь гаргаж буй 2 дахь удаагийн хэвлэл бөгөөд энэ нь 2010 оны тооллогоор цуглуулсан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэлд тулгуурласан шинжилгээгээрээ онцлогтой болно.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн идэвхийн талаарх мэдээллийг цуглуулах, боловсруулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) болон Үндэсний Статистикийн Хорооны дарга, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2009 оны 01-681/94 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг ашигласан нь 2010 оны тооллогын үр дүнг Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого болон бусад судалгааны үр дүнтэй харьцуулах боломжийг олгож байгаа юм. Мөн 2010 онд шинэчлэгдэн батлагдсан "Үндэсний ажил мэргэжлийн ангилал (ISCO-08)", "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажилагааны салбарын ангилал (ISIC-4.0)" зэргийг ашигласан болно.

Манай орны хувьд сүүлийн 10 жилийн хугацаанд хүн ам зүйн үзүүлэлтэд ихээхэн өөрчлөлт гарсантай холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид өөрчлөлт гарсаар байна. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний бодлогод өөрчлөлт орох шаардлага байгааг харуулж байна.

## 6.1 ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр Монгол Улсын нийт хүн амын 69.2 хувь нь 15, түүнээс дээш насны хүн ам байгаа бөгөөд эдгээрээс 56.4 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам - ажиллах хүчинд багтаж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өндөр байгаа хэдий ч эрэгтэйчүүд болон улсын дунджаас 6.3-12.9 пунктээр доогуур байна.

Төсөөлж байснаас ажиллах хүчний оролцоо хөдөөд, хотынхоос өндөр байгаа төдийгүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн алинд ч энэ түвшин нь хадгалагдаж байна. Энэхүү ерөнхий дүр төрх насны бүх бүлэгт ажиглагдлаа.

Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) 35-39 насанд хамгийн өндөр буюу 77.6 хувь байгаа бөгөөд ихэнх аймагт энэ насны бүлэгт энэ түвшин мөн өндөр байгаа юм. Түүнчлэн Өмнөговь аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин насны бүх бүлэгт бусад аймгаас харьцангуй өндөр байна.

Ажиллах хүчний оролцоо нь эдийн засгийн хамгийн идэвхтэй нас болох 25-24 насанд, ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд төсөөлж байснаас нилээд доогуур байв. Ажиллах хүчний оролцоо доогуур байгаа нь **тохирох ажил олдохгүй байгаагийн** улмаас ажил хайхгүй байгаа, мөн **сургуульд суралцдаг** гэсэн шалтгаанууд нилээд хувийг эзэлж байгаагаас шалтгаалж байна. Сургуульд суралцаж буй хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байгаа нь ялангуяа хотын залуучуудын ажиллах хүчний оролцоонд илүү нөлөөлж байгаа юм.

Өөр нэг шалтгаан бол ажиллах хүчнээс гаднах хүн ам, ялангуяа эмэгтэйчүүдийн дунд гэрийн ажилтай болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд тэтгэврийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгаа явдал юм.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бусад судалгаагаар эдийн засгийн идэвхгүй байгаа хүн амын дотор ажиллах сонирхолгүй хүн ам багагүй хувийг эзэлж байгаа тул 2010 оны тооллогын асуулгад уг шалтгааныг илрүүлэхээр нэмэлт хийсэн бөгөөд энэ үзүүлэлт нь улсын дүнгээр 14.6 хувь, эрэгтэйчүүдийн хувьд 21.4 хувийг эзэлж байна.

Мөн хүн амын эдийн засгийн идэвхийн байдалд гэр бүлийн байдал, боловсрол, шилжих хөдөлгөөн, хөгжлийн бэрхшээлийн байдал зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлж байдаг тул эдгээр хүчин зүйлсээр зарим судалгаа хийжээ.

Гэр бүлийн байдлаар авч үзвэл ажиллах хүчний оролцоо гэр бүлтэй эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийнхээс дээгүүр байгаа нь эрэгтэйчүүд цалин, орлоготой ажил олсныхоо дараа гэр бүл болдог, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нь тэдний гэр бүлийн болон хүүхэд асрах үүрэг хариуцлагаас шалтгаалж байгааг харуулж байна. Тухайлбал, 2010 оны тооллогын үр дүнгээр батлуулсан гэр бүлтэй хүмүүсийн АХОТ 68.0 хувь, батлуулсан гэр бүлтэй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 74.2 хувь байгаа юм.

Ажиллах хүчний оролцоо бэлбэсэн хүмүүсийн дунд хамгийн бага 25.6 хувь байна. Гэрлэлтээ цуцалсан эсвэл бэлбэсэн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь залуу насны бүлэгт өндөр, харин ахмад насны бүлэгт маш доогуур байна. Энэ нь залуудаа салсан буюу бэлбэсэрсэн эмэгтэйчүүд өөрсдийнхөө болон үр хүүхдийнхээ төлөө ажил хөдөлмөр эрхлэх шаардлагатай байдаг бол өндөр настнуудад үр хүүхдүүд нь тэднийг харж хандаж байдгийг харуулж байна.

Боловсрол болон ажиллах хүчний оролцооны хооронд эерэг хамаарал, өөрөөр хэлбэл ажиллах хүчний оролцооны түвшин өндөр боловсролтой хүмүүсийн дунд дээгүүр, бага боловсролтой болон боловсролгүй хүмүүсийн дунд доогуур байгаа нь хот болон хөдөөд түүний нэгэн адил ажиглагдаж байна. Гэхдээ боловсролын түвшин, ажиллах хүчний оролцооны хоорондын энэ хамаарал хотод хөдөөгөөс илүү мэдэгдэхүйц байна.

